



БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН ЯАМ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ  
ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ  
ТОДОРХОЙЛОХ, БАГШЛАХ АРГА  
ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

ISBN 991995194-3



Улаанбаатар хот  
2019 он

ННА-74.3

ДАА-371.9

Х-543

**Хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүс:**

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН “БАСАРХАН” ЦЭЦЭРЛЭГ

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 42-Р ЦЭЦЭРЛЭГ

Р.БААСАНЖАРГАЛ

Ц.МӨНХТУЯА

Б.БУЛГАМАА

Б.НАРАНСҮЛД

Н.ГЭРЭЛТ-ОД

**Хянасан:**

БСШУСЯ-ны Боловсролын хүрээлэнгийн тусгай хэрэгцээт  
боловсролын хөтөлбөрийн судалгаа хариуцсан  
эрдэм шинжилгээний ажилтан

Ц.ЦЭВЭГМИД

Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургууль,  
согог зүйч багш

Ч.АЛТАНЦЭЦЭГ

Ерөнхий боловсролын 55 дугаар тусгай сургууль,  
сургалтын менежер

Ж.ОТГОНЦЭЦЭГ

Ерөнхий боловсролын 63 дугаар тусгай сургууль,  
сургалтын менежер

О.МӨНХЦЭЦЭГ

Ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургууль,  
согог зүйч багш

Т.НАРАНЧИМЭГ

*Энэхүү ном нь Монгол улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар баталгаажсан  
тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх,  
цахим болон бусад хэлбэрээр хувиран олируулах, түгээн тараахыг хориглоно.*

ISBN: 978-9919-9519-4-8

## ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	4
<b>ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ</b>	6
<b>I. Өөртөө үйлчлэх энгийн чадвар</b>	8
I-1 Цэвэрлэх, хураах	8
I-2 Гар угаах	10
<b>II. Хөдөлгөөн, үйл ажиллагаа</b>	13
II-1 Бөмбөг тоглох	13
II-2 Дүрсийг хэвэнд хийх	17
II-3 Модон шоо	20
II-4 Сав болон багаж хэрэгсэл, эд юмс	23
II-5 Цагираг ба уяа	26
II-6 Цахилгаан, товч, цаас	29
II-7 Модон дүрсийг “Пэг” тоглоомын сууринд хийх	39
II-8 Үйл ажиллагаа	35
<b>III. Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол</b>	39
III-1 Дүрс, өнгө болон эд юмсыг зориулалтаар нь нийлүүлэх, ялгах	39
III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	49
III-3 Үсэг унших	56
III-4 Тоо, хэмжээ	60
III-5 Эд зүйлийн шинж чанар	68
III-6 Эд юмсын зориулалт	70
<b>IV. Харилцаа, нийгэмшихүй</b>	72
IV-1 Өөрийгөө илэрхийлэх	72
IV-2 Өдөр тутмын амьдрал дээрх нийтлэг дүрэм	76

## ӨМНӨХ ҮГ

### 1. ЗОРИЛГО

Энэхүү гарын авлагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бодит байдлыг судалж, тухайн хүүхдийн хөгжих, сурах онцлогт тохирсон даалгаврыг боловсруулахад ашиглах боломжтой жишээнүүдийг дэлгэрэнгүй оруулсан болно. Уншиж, бичиж чаддаггүй, тоо хэмжээний ойлголтыг бүрэн ойлгож, эзэмшиж чадаагүй хүүхдэд тус гарын авлагаас санаа авч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж өдөр тутмын хичээлдээ ашиглах боломжтой.

Хүүхэд бүрийн хөгжил харилцан адилгүй боловч хүүхдийн хөгжлийн ай, үе шатуудад ижил төстэй зүйлүүд байдаг. Сургалтын явцад багшаас хүүхдийн хөгжлийн түвшинд тохироогүй даалгавар өгөх тохиолдол байсаар байна.

Тус гарын авлагад 1-5 түвшинд хөгжлийн ай тус бүрээр хүүхдийн хөгжих, сурах онцлогт тохирсон даалгавруудыг оруулсан болно. “Хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт”-ийг ашиглан тодорхой үе шаттайгаар хүүхдээ дэмжсэн арга зүйг сонгон ажиллахыг багш та бүхнээсээ хүсье.

Мөн БСШУС-ын сайдын 2018 оны А/425 дугаар тушаал “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 3.16-д “Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ” гэсэн заалтыг үндэслэн энэхүү гарын авлагыг ашиглаж хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ахиц, өөрчлөлтийн явцын үнэлгээг хийж болно.

### 2. АГУУЛГА

Гарын авлага нь “Хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт”, “Багшлах арга зүйн дэлгэрэнгүй жишээ” гэсэн 2 бүлэгтэй. Хүүхдийн хөгжлийг ерөнхийд нь 4 том айд хуваасан ба энэхүү хөгжлийн ай нь ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварын хөгжлийн айтай ижил болно<sup>1</sup>.

<sup>1</sup> БСШУС-ын сайдын 2018 оны 3-р сарын 29-ний өдрийн А/155 тоот тушаал

1. Өдөр тутмын амьдралд шаардлагатай ухагдахууныг ойлгож, эзэмших - **“Өөртөө үйлчлэх энгийн чадвар”**
2. Бүх биеийн болон гар хурууны хөдөлгөөн - **“Хөдөлгөөн, үйл ажиллагаа”**
3. Үг, дүрс, тооны ухагдахууныг ойлгож, эзэмших - **“Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол”**
4. Өөрийн бодол санааг илэрхийлэх, нийгмийн дүрэм журмыг ойлгох, дагаж мөрдөх - **“Харилцаа, нийгэмшихүй”**

Хүүхдийн хөгжил тус бүр тодорхой үе шаттай. Жишээлбэл: 1 гэдэг тооны утгыг ойлгосон хүүхэд удалгүй 5 хүртэлх зүйлсийг тод, зөв тоолж чаддаг болно. Цаашлаад 10 хүртэлх зүйлсийг тод, зөв тоолж чаддаг болдог. Эсрэгээрээ 1 гэдэг тооны утгыг ойлгож чадаагүй хүүхэд 5 болон 10 хүртэлх зүйлсийг тод, зөв тоолж чаддаг болох нь нэлээд хүндрэлтэй.

Оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн хувьд танин мэдэхүйн хөгжил нь удаан байдгаас ижил насны хүүхдүүдтэй нэг ангид суралцахад хүндрэлтэй байдаг. Эдгээр хүүхдүүдтэй ажиллахдаа хөгжлийн ай болон үе шатыг харгалзан хүүхэд нэг бүрийн бодит байдалд нийцсэн хичээл төлөвлөлтийг боловсруулах нь чухал юм.

### 3. “Хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт”-ийг ашиглах заавар

Таны зааж байгаа хүүхдүүд дунд, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөрөөр суралцахад хүндрэлтэй хүүхэд байгаа бол хавсралт хүснэгтэд байгаа “Хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт”-ийг ашиглан 4 ай тус бүрт өгөгдсөн даалгаврыг гүйцэтгүүлж, бодит байдлыг шалгаарай.

Хүүхэд даалгаврыг гүйцэтгэж чадаж байвал дугуй /○/, чадахгүй байвал чагт /×/ -аар тэмдэглэнэ. “Хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт” –ийг ашиглаж Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулна. Хүүхдийн одоогийн хийж чадаж байгаа түвшний агуулгаас ахиулж, дараагийн түвшний агуулгыг урт хугацааны зорилт болгон тавина.

Жишээлбэл: **Өөртөө үйлчлэх энгийн чадвар ай** дахь **I-2** даалгаварт “Гар угаах” агуулгыг **Түвшин 2** буюу “**Цоргоноос гоожиж буй усаар гараа угаах**” гэсэн агуулгыг гүйцэтгэж чадаж байгаа бол **Түвшин 3** буюу “**Бусдын зааврын дагуу гар угаах дарааллыг зөв гүйцэтгэх**” гэсэн агуулгыг хийлгэж үзээд, чадахгүй байгаа тохиолдолд **Түвшин 3**–ын даалгаврыг урт хугацааны зорилт болгон тавина.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ, БАГШЛАХ АРГА ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ

Хөгжлийн ай	Агуулга	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 4	Түвшин 5	
I Өөртөө үйлчлэх зүйлийн чадвар	I - 1 Цэвэрлэж хураах		1. Даалгавраа хийж дуусаад хэрэглэсэн үйлдээ хураах	2. Хоолоо идээ, шал агта тавар зэргэ хэрэглэсэн үйлдээ хураах			
	I - 2 Гараа угаах		3. Цоргонгос тооцож буй усаар гараа цэвэрлэх	4. Бусдын зааврыг дагуу гар угаах дарааллыг зөв тооцож хэрэглэх	5. Бие дааж дарааллын дагуу гараа угаах		
II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II - 1 Бөмбөг тоглох		6. Бай руу бөмбөг шидэх				
			7. Бөмбөг шидэхгэн өнхрүүлэх	8. Том бөмбөг бөмбөг авах	9. Жижиг бөмбөг барьж авах		
	II - 2 Хэвцэгс гаргах, хийх	10. Хэвцэгс дунд дүрсийг гаргуу	11. Дугуй дүрсийг эвэлд хийх	12. Дүрсүүдийг эвэлд тохируулж хийх			
	II - 3 Ордог модон шоо	13. Хоёр гартаа барьсан модон шоог хоёронд нь нийлүүлэх	14. 3 хүртэл модон шоог орох	15. Модон шоог агуулж ямар нэг дүрс хийх			
	II - 4 Сав болон багаж хэрэгсэлд жомс	16. Саванд байгаа эд жомсыг гаргаж авах	17. Саванд жомс хийх	18. Халбага, хавцар зэргийг ашиглаж эд жомсыг савнаас гаргах, буцааж хийх			
	II - 5 Цагираг ба уяа	19. Уяанд хэлхээн шүршиг суулаа	20. Нэг ширхэг шүршүүр будуун уяа суулгах	21. 5 ширхэг цагираг будуун уяа суулгах			
	II - 6 Цахилаан, товч, наас		22. Уутны цахилааныг нээх, хаах	23. Том товч тайлах		24. Цаасыг дундуур нь нугалан дутууд хийх	
	II - 7 "Пэг" суурин тоглоом, наалт	25. "Пэг" суурин модон дүрсээ суулгаж авах	26. "Пэг" суурин модон дүрсээ хийх	27. Хүрээний язгаар дотор наалт наах			
II - 8 Гар ажиллагаа		28. Дүрсээ шидэж хүрээ дотор наах		29. Хайчаар үзүүр болон муруй шугамыг дагуу хайцгах	30. Муруй шугам болон өнцөг гарган өнгүй хайцгах		
III Хэл яриа, гавни мэдэхүй, тоо тоолол	III - 1 Дүрс, өнгө, тохирох, эс тохирохыг ялгах		31. Ижил дүрсүүдийг нэгтгэж, ангилах	34. Хэлбэрээр нь ялгасуулж нэгтгэх	37. Ижил хэлбэр дүрсээр нь ангилах		
			32. Ижил зурвасыг нэгтгэх				
			33. Өнгөөр нь ялгасуулж нэгтгэх	36. Ижил өнгөтэй жомсыг нэгтгэх	39. Эд зүйлсийг зориулалтаар нь ангилах		
			40. Сарнаа хийх	41. Бусдын зурсныг дуурайн нэмэх, дөрвөлжин дүрс, ташуу зурсах	43. Бусдын зурсныг дуурайн нэмэх, дөрвөлжин дүрс, ташуу зурсах	45. Бусдын зурсныг дуурайн гурвалжин дүрс, хэлбэр үсэг зургах	
	III - 2 Дүрс, үсэг бичих			42. Том хүү дүрсийг дугуй дүрс зургах	44. Шугуун болон нуман зурвасыг балаар зургах	46. Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүдийг балаар зургах	
						47. Өөрийнхөө нэрэнд ордог үсгийг олох	48. Өөрийн нэрийнхээ бүх үсгийг олох
	III - 3 Үсэг унших					49. Бүх тоог олох	
						50. 4 хүртэл үсэгтэй үгийг харж ойлгон, тохирох зүйлийг олох	
						51. 3 хүртэл тооны жижиг зүйлүүдийг нэгтгэх	54. 3 хүртэл хүсэснийг авч олох
	III - 4 Тоо ширхэг, хэмжээ				52. 1 тооны утгыг олох	55. 5 ширхэг үсгийг чанга дуугаар зөв тоолох	57. 10 ширхэг зүйлийг чанга дуугаар зөв тоолох
					53. 1 тооны үсэг ойлгох, 1 ширхэг зүйл тавьсан үсгийг нэгнөх		58. 5 хүртэл тооны жомсыг тохирох цифртэй харгалзуулах
						59. Ижил 2 зүйлээс том, жижгийг нь сонгох	60. Ижил 2 зүйлээс урт, богиныг сонгох
III - 5 Эд жомсын харьяалал					61. Эд жомсын зориулалтын нэршлийг олох	62. Эд жомсын зориулалтыг тайлбарлах	
	III - 6 Эд жомсын зориулалт						
IV Харилцаа, Нийгэмшүүхүй	IV - 1 Санаа бодлоо илэрхийлэх		63. 2 ширхэг зүйлээс 1-ийг нь зааж, хари сонгож авах	64. 2 зургааны өөрт танигдах зүйлийг сонгох	66. Өөрч хэрэгсэл байгаа үйлдлээ зурж хариулах		
				65. "Надаа" гэдэг үгийг үйлдлээ эсвэл үгээр илэрхийлэх			
	IV - 2 Хэл ярианы ойлголт, асууц, хариулах				67. Ээлж дарааллыг ойтгуулах тоглоом тоглох	68. "За, май", "Бавраллаа", "Уучлаарай" зэрэг үгийг хэрэглэх	

4. “Багшлах арга зүйн дэлгэрэнгүй жишээ”-г ашиглах заавар

“Хөгжлийн түвшинг тодорхойлох хүснэгт”-ийг ашиглан хүүхдийн бодит байдлыг судлаж мэдсэний дараа хичээлийн цагаар болон ганцаарчилсан сургалтын үед багшлах арга зүйн тухай авч үзье.

Тус гарын авлагын “Багшлах арга зүйн дэлгэрэнгүй жишээ”-нд хичээлийн явцад ижил даалгаврыг өөр өөр орчинд хийлгэж үзэх, хэрэглэгдэхүүнээ өөрчлөх санааг оруулснаас гадна багшийн зүгээс аливаа даалгаврыг хүүхдээр хийлгэх явцад анхаарах зүйлсийг зөвлөмжилсөн болно.

## ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ХҮСНЭГТ

Хөгжлийн ай	Агуулга	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 4	Түвшин 5	
<b>I</b> Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I - 1 Цэвэрлэж хураах		1. Даалгавараа хийж дуусаад хэрэглэсэн зүйлээ хураах	2. Хоолоо идэж дуусаад аяга таваг зэрэг хэрэглэсэн зүйлээ хураах			
	I - 2 Гараа угаах		3. Цоргоноос гоожиж буй усаар гараа норгох	4. Бусдын зааврын дагуу гар угаах дарааллыг зөв гүйцэтгэх	5. Бие дааж дарааллын дагуу гараа угаах		
<b>II</b> Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II - 1 Бөмбөг тоглох		6. Бай руу бөмбөг шидэх				
			7. Бөмбөг шидэх, өнхрүүлэх	8. Том бөмбөг барьж авах	9. Жижиг бөмбөг барьж авах		
	II - 2 Хэвнээс гаргах, хийх	10. Хэвнээс дугуй дүрсийг гаргах	11. Дугуй дүрсийг хэвэнд хийх	12. Дүрсүүдийг хэвэнд тохируулж хийх			
	II - 3 Өрдөг модон шоо	13. Хоёр гартаа барьсан модон шоог хооронд нь нийлүүлэх	14. 3 хүртэл модон шоог өрөх	15. Модон шоог эвлүүлж ямар нэг дүрс хийх			
	II - 4 Сав болон багаж хэрэгсэл, эд юмс	16. Саванд байгаа эд юмсыг гаргаж авах	17. Саванд эд юмс хийх	18. Халбага, хавчаар зэргийг ашиглаж эд юмсыг савнаас гаргах, буцааж хийх			
	II - 5 Цагираг ба уяа	19. Уяанд хэлхсэн шүрийг сугалах	20. Нэг ширхэг шүр бүдүүн уяа сүвлэх	21. 5 ширхэг цагирагт бүдүүн уяа сүвлэх			
	II - 6 Цахилгаан, товч, цаас		22. Уутны цахилгааныг нээх, хаах	23. Том товч тайлах		24. Цаасыг дундуур нь нугалан дугтуйд хийх	
	II - 7 “Пэг” суурин тоглоом, наалт	25. “Пэг” сууринаас модон дүрсээ сугалж авах	26. “Пэг” сууринд модон дүрсээ хийх	27. Хүрээний хязгаар дотор наалт наах			
II - 8 Гар ажиллагаа		28. Дүрсээ цавуудаж хүрээ дотор наах		29. Хайчаар шулуун болон муруй шугамын дагуу хайчлах	30. Муруй шугам болон өнцөг гарган өөгүй хайчлах		
<b>III</b> Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III - 1 Дүрс, өнгө, тохирох, эс тохирохыг ялгах		31. Ижил зүйлүүдийг нэгтгэх, ангилах	34. Хэлбэрээр нь ижилсүүлж нэгтгэх	37. Ижил хэлбэр дүрсээр нь ангилах		
			32. Ижил зургуудыг нэгтгэх				
			33. Өнгөөр нь ижилсүүлж нэгтгэх	35. Зургаар үзүүлсэн эд зүйлийг олох	38. Дүрс өөр боловч, нэг төрлийн зүйлийг ангилах		
	III - 2 Дүрс, үсэг бичих		40. Сараачих	41. Бусдын зурсныг дуурайн хөндлөн, босоо зураас зурах	43. Бусдын зурсныг дуурайн нэмэх, дөрвөлжин дүрс, ташуу зураас зурах	45. Бусдын зурсныг дуурайн гурвалжин дүрс, хялбар үсэг зурах	
				42. Том хүн дуурайж дугуй дүрс зурах	44. Шулуун болон нуман зураасыг балаар зурах	46. Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүдийг балаар зурах	
	III - 3 Үсэг унших				47. Өөрийнхөө нэрэнд ордог үсгийг олох	48. Өөрийн нэрийнхээ бүх үсгийг олох	
						49. Бүх тоог олох	
	III - 4 Тоо ширхэг, хэмжээ				51. 3 хүртэл тоотой ижил зүйлүүдийг нэгтгэх	54. 3 ширхэг зүйл хүссэнийг авч өгөх	56. 10 ширхэг зүйл хүссэнийг авч өгөх
					52. 1 тооны утгыг ойлгох	55. 5 ширхэг зүйлийг чанга дуугаар зөв тоолох	57. 10 ширхэг зүйлийг чанга дуугаар зөв тоолох
					53. 1 тооны утгыг ойлгон, 1 ширхэг зүйл тавьсан тавгийг сонгох		58. 5 хүртэл тоотой юмсыг, тохирох цифртэй харгалзуулах
	III - 5 Эд юмсын харьяалал				59. Ижил 2 зүйлээс том, жижгийг нь сонгох	60. Ижил 2 зүйлээс урт, богиныг сонгох	
	III - 6 Эд юмсын зориулалт				61. Эд юмсын зориулалтын нэршлийг ойлгох	62. Эд юмсын зориулалтыг тайлбарлах	
<b>IV</b> Харилцаа, Нийгэмшихүй	IV – 1 Санаа бодлоо илэрхийлэх		63. 2 ширхэг зүйлээс 1-ийг нь зааж, хүрч сонгож авах	64. 2 зурагнаас өөрт таалагдах зүйлийг сонгох	66. Өөрт хэрэгтэй байгаа үйлдлээ зургаар заах		
				65. “Надаа” гэдэг үгийг үйлдэл эсвэл үгээр илэрхийлэх			
IV – 2 Хэл ярианы ойлголт, асуух, хариулах					67. Ээлж дарааллыг ойлгуулах тоглоом тоглох		
						68. “За, май”, “Баярлалаа”, “Уучлаарай” зэрэг үгийг хэрэглэх	



**БАГШЛАХ АРГА  
ЗҮЙН ДЭЛГЭРЭНГҮЙ  
ЖИШЭЭ**



# I ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ ЭНГИЙН ЧАДВАР

## 1 I-1 Цэвэрлэх, хураах

Даалгавар 1	I Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I-1 Цэвэрлэж хураах	Түвшин 2
Агуулга	Даалгавраа хийж дуусаад хэрэглэсэн зүйлээ хураах		
Орчин	Хичээл дууссаны дараа /хэрэглэсэн сургалтын хэрэглэгдэхүүн ширээн дээр байна/		
Хэрэглэгдэхүүн	Сургалтын хэрэглэгдэхүүн, сагс		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдэд сагс өгнө. /цэвэрлэж хураах сагс урьдчилан бэлдсэн байна/</li> <li>2. Хүүхэд хэрэглэгдэхүүнээ сагсанд хийж багшдаа өгнө.</li> <li>3. Хэрэглэгдэхүүнээ сагсанд хурааж чадсан бол урамшуулна.</li> </ol>		



*Сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрэглэж дууссаны дараа сагсанд хийх*



*Сагсанд хийж чадсан бол магтах*

Даалгавар 2	I Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I-1 Цэвэрлэж хураах	Түвшин 3
Агуулга	Хоолоо идэж дуусаад аяга таваг зэрэг хэрэглэсэн зүйлээ хураах		
Орчин	Хоол идсэний дараа		
Хэрэглэгдэхүүн	Хоолны хэрэгсэл /аяга, халбага, таваг/, сагс		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Хоолоо идэж дуусаад “Аяга, тавгаа хураагаарай” гэж хэлнэ. <ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд аяга, тавгаа хураахдаа хэд хэд хувааж зөөж болно.</li> <li>Аяга, таваг хураах сав, байрлалыг тодорхой хэлж өгнө</li> </ul> </li> <li>Хурааж дууссаны дараа магтана.</li> </ol>		



Хооллох



Хооллосны дараа аяга тавгаа хураах

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- А Өөрийн эд зүйлийг цүнхэндээ хийх .
- Бусдын юмнаас ялгахад хялбар байх үүднээс таних тэмдэг тавих.
- В Анги доторх эд юмс, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлдэж, тогтсон газарт хураах.
- Анги дотор хураах газрыг тогтоож, ойлгомжтой зурган тэмдэглэгээ хийсэн байх.

Дээрх А, В-д өгөгдсөн зүйлийг дараах дарааллаар хийж, чадсан тохиолдолд магтана.

1. Бусдын тусламжтайгаар хийж чаддаг болох.
2. Тусламж шаардлагатай бол хамгийн сүүлийн үйлдэл дээр хүүхдээр өөрөөр нь хийлгэх.
3. Аливаа үйлдлийг хийхэд бага багаар дэмжлэг үзүүлэн, бие даан гүйцэтгэдэг болгох.
4. Хөндлөнгөөс дэмжлэг үзүүлэхгүй, аман заавар өгч хурааж цэгцлүүлэх.
5. Хүүхдийн нэрийг дуудаж, эд юмсыг цэгцлүүлэх, хураалгах.

## I-2 Гар угаах

Даалгавар 3	I Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I-2 Гар угаах	Түвшин 2
Агуулга	Цоргоноос гоожиж буй усаар гараа норгох		
Орчин	Гар угаах		
Хэрэглэгдэхүүн	Алчуур		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Багш цоргыг нээж, хүүхдийг “Гараа угаагаарай” гэж хэлнэ.</li><li>2. Хүүхэд гараа норгосны дараа алчуур өгч арчуулна.</li><li>3. Хийж чадвал магтана.</li></ol>		



*Гоожиж буй усанд гараа норгох*




*Алчуур өгөхөд гараа арчих*

Даалгавар 4	I Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I-2 Гар угаах	Түвшин 3
Агуулга	Бусдын зааврын дагуу гар угаах дарааллыг зөв гүйцэтгэх		
Орчин	Гар угаах		
Хэрэглэгдэхүүн	Гар угаах зурагт карт, саван, алчуур		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш хүүхдэд цоргыг нээж, гар угаах дарааллыг тухай бүрд нь зааварчилж гарыг угаалгана. /Цоргыг хаах үйлдлийг нэмж болно/</li> <li>2. Багш аман зааварчилгааг багасгаж аажмаар хүүхэд бие даан гараа угаахад сургана. <ul style="list-style-type: none"> <li>• Гар угаах дарааллыг харуулсан зурагт картаа бэлтгэж, хүүхдэд харуулангаа үйлдлийг хийлгэх нь зүйтэй.</li> </ul> </li> </ol>		



*Гар угаах дарааллыг тайлбарлах*



*Зааврыг харж гараа угаах*

Даалгавар 5	I Өөртөө үйлчлэх энгийн чадвар	I-2 Гар угаах	Түвшин 4
Агуулга	Бие дааж, зөв дарааллын дагуу гараа зөв угаах		
Орчин	Гар угаах		
Хэрэглэгдэхүүн	Гар угаах зурагт карт, саван, алчуур		
Дараалал	<ul style="list-style-type: none"> <li>• Гар угаах бүх алхмыг дарааллын дагуу хүүхдээр бие даалгаж хийлгэнэ.</li> <li>• Хүүхэд бүх алхмыг зурагт карт харж, түүний дагуу угааж болно.</li> </ul>		



Гар угаах зурагт картыг харангаа  
гараа угаах



Өөрөө гараа арчих

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- Хүүхдэд гар угаахыг заахдаа эхлээд саванд хийсэн усанд гарыг нь дүрж норгоод, багшийн дэмжлэгтэйгээр гараа угаах алхам бүрийг ойлгуулах.
- Гар угаах үйлдлийг сургах явцдаа дуусах хэсгээс нь бага багаар багш дэмжлэгээ багасгах. Энэ үед Энэ үед тухайн үйлдлийг аман зааварчилгаагаар давтан хэлж өгөх.



### Анхаарах зүйл

- Гар угаах үйлдлийг хураах, цэвэрлэх үйлдэлтэй холбож болно. Хүүхэд гараа бохирдсон /хог, хоолны үлдэгдлийг хамж хаях г.м/ үед “Гараа савандаж угаагаарай” гэж анхааруулан гараа угаах хэрэгтэйг ойлгуулах нь зүйтэй.

## II ХӨДӨЛГӨӨН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

### II-1 Бөмбөг тоглох

Даалгавар 6	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-1 Бөмбөг тоглох	Түвшин 2
Агуулга	Бөмбөг шидэж, сагсанд оруулах		
Орчин	Биеийн тамирын хичээл, тоглоомын цагийн үеэр		
Хэрэглэгдэхүүн	Том бөмбөг, бөмбөг багтах том сагс		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Хүүхдээс 30см-ээс 1м-ийн зайд тавьсан сагс руу бөмбөг шидэж оруулах заавар өгнө. Сагсанд бөмбөгөө оруулж чадвал магтаж урамшуулна.</li><li>2. Сагсны байрлалыг бага багаар холдуулна. Бөмбөгийг зөвхөн хол шидэх бус, онож оруулахыг эрмэлзэх, чадсан үед багш хүүхдийг урамшуулна.</li></ol>		

6



Сагсыг бага багаар холдуулах



Бөмбөгөө шидэж оруулах

Даалгавар 7	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-1 Бөмбөг тоглох	Түвшин 2
Агуулга	Бөмбөг шидэх/өнхрүүлэх		
Орчин	Биеийн тамирын хичээл, тоглоомын цагаар		
Хэрэглэгдэхүүн	Том бөмбөг /диаметр 20 см орчим/		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Хүүхдэд бөмбөг өгнө.</li><li>2. Багш хүүхдээс бага зэрэг зайтай зогсож “Бөмбөгөө шидээрэй/өнхрүүлээрэй” гэж хэлнэ. Чадвал магтана.</li><li>3. Бөмбөгөө шидэх зайг өөрчилж дахин давтан хийнэ. Хүүхдийг харилцагч руу анхаарлаа хандуулж байгааг нь магтана.</li></ol>		

7



*Том бөмбөгийг өнхрүүлэх*



*Том бөмбөгийг шидэх*

Даалгавар 8	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-1 Бөмбөг тоглох	Түвшин 3
Агуулга	Том бөмбөг барьж авах		
Орчин	Биеийн тамирын хичээл, тоглоомын цагаар		
Хэрэглэгдэхүүн	Том бөмбөг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдэд анхааруулсны дараа бөмбөгийг шидэж/өнхрүүлж өгнө.</li> <li>2. Хүүхэд бөмбөгийг барьж авсны дараа “Буцааж бөмбөгөө шидээрэй/өнхрүүлээрэй” гэж хэлнэ. Чадвал магтана.</li> <li>3. Бөмбөгний шидэх хурд, зайг өөрчилж дахин давтан хийнэ. Хүүхдийг харилцагч руу анхаарлаа хандуулж байгааг нь магтана.</li> </ol>		



*Багш бөмбөг шидэхэд хүүхэд барьж авах*



*Хүүхэд барьж авсан бөмбөгөө багш руу буцааж шидэхийг хүсэх*





Даалгавар 9	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-1 Бөмбөг тоглох	Түвшин 4
Агуулга	Жижиг бөмбөг барьж авах		
Орчин	Биеийн тамирын хичээл, тоглоомын цагийн үеэр		
Хэрэглэгдэхүүн	Түвшин 3-аас жижиг бөмбөг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдэд анхааруулсны дараа бөмбөг шиднэ.</li> <li>2. Хүүхэд бөмбөг барьж авангуут “Багш руугаа шидээрэй” гэж хэлнэ. Хүүхэд багш уруу шидэж чадвал магтана.</li> <li>3. Бөмбөгний хурд, өндөр, хоорондын зайг өөрчлөөд дахин давтан хийнэ. Хүүхэд харилцагч руугаа анхаарал хандуулж байгааг магтана.</li> </ol>		



*Багш жижиг бөмбөг хүүхэд урүү шидэх*



*Хүүхэд бөмбөгийг барьж авах*

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- Бөмбөгөөр тоглох даалгаврыг зөвхөн хичээл дээр хийх биш, гэртээ, гадаа тоглох боломжийг нэмэгдүүлэхийг гэр бүлийнхэнд нь зөвлөх.
- Хүүхдийн хөгжлийн үе шатыг сайтар мэдэж, хүүхдэд тохирсон даалгаврыг өгнө. Эхний ээлжинд бөмбөг нь зөөлөн байх бөгөөд хүүхэд барьж авахад гар өвдөхөөргүй байх. Хийлдэг бөмбөлөг ойлт удаан, шидэж барьж авахад хялбар бөмбөгийг бэлдэх.



#### **Анхаарах зүйл**

Тоглоомын дүрэм болон бөмбөгний хэмжээг хүүхдийн одоогийн бодит байдалд нь тохируулан сонгож, хөгжлийн үе шатад нь тохирч байхаар төлөвлөнө. Биеийн тамирын хичээлийн явцад ашиглаж болно.

## II-2 Дүрсийг хэвэнд хийх

Даалгавар 10	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-2 Дүрс эвлүүлэх	Түвшин 1
Агуулга	Хэвнээс дугуй дүрсийг гаргах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Дүрс, дүрс хийх хэв		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Багш дүрсийг нэг нэгээр нь хэвэнд хийж үзүүлнэ.</li><li>2. Багш хүүхдэд "Дүрсийг хэвнээс гаргаарай" гэж хэлнэ.</li><li>3. Хүүхэд дүрсийг гаргаж чадвал магтана.</li><li>4. "Таргасан дүрсээ багшдаа өгөөрэй" гэж хэлэхэд хүүхэд дүрсийг авч өгсөн тохиолдолд магтана.</li><li>5. Хэвийг багшид өгөхийг хүсэхэд өгсөн тохиолдолд магтана.</li></ol>		

10



*Хэвнээс дугуй  
дүрсийг гаргах*

Даалгавар 11	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-2 Дүрсийг хэвэнд хийх	Түвшин 2
Агуулга	Дугуй дүрсийг хэвэнд хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Дүрс, дүрс хийх хэв		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Багш дугуй дүрсийг хүүхдэд өгнө. Дүрс хийх хэв өгч, хаана хийх байрыг заалгүй “Хэвэнд хийгээрэй” гэж хэлнэ. Туршиж үзэж болно.</li><li>2. Хүүхэд чадвал магтана.</li></ol>		

11



*Хэвэнд дугуй  
дүрсийг хийх*

Даалгавар 12	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-2 Дүрс эвлүүлэх	Түвшин 3
Агуулга	Дүрсүүдийг тохирох хэвэнд хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Дүрс, дүрсний хэв		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш хэв өгч хаана хийхийг заалгүй “Дүрсийг хийгээрэй” гэж хэлнэ. Туршиж үзнэ.</li> <li>2. Хүүхэд хийж чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>• Туршиж хийж үзэх түвшин, хэв болон дүрсийг харьцуулан харж, шууд хийх түвшин гэж байна. Хүүхдээ ажиглаад, аль түвшинд нь байна гэдгийг үнэлнэ.</li> </ul> </li> </ol>		



*Хэвэнд дөрвөлжин дүрсийг хийх*



*Хэвэнд гурвалжин дүрсийг хийх*

## II-3 Модон шоо

Даалгавар 13	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-3 Модон шоо	Түвшин 1
Агуулга	Хоёр гартаа барьсан модон шоог хооронд нь хавсран цохиж дуу гаргах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Ижил хэмжээтэй жижиг модон шоо 4 ширхэг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш 2 гартаа нэг нэг модон шоо барьж үзүүлээд, хүүхдэд мөн “2 гартаа модон шоо бариарай” гэж хэлнэ.</li> <li>2. Багш 2 модон шоог хавсран цохиж дуу гаргаж үзүүлнэ. “Дуурайгаад хийгээрэй” гэж хэлнэ. Хийж чадвал магтана.</li> <li>3. Багш дуу гаргах тоог өөрчилж, хүүхдээр дагуулан хийлгэнэ.</li> </ol>		

13



*Багш, хүүхэд аль аль нь хоёр гартаа нэг нэг модон шоо барих*



*Багш шоонуудыг хооронд нь нийлүүлж үзүүлнэ. Хүүхдээр дуурайлган хийлгэх*



### Анхаарах зүйл

- Хөгжмийн хичээл дээр шагшуур хөгжим ашиглаж, багшийг дуурайн хөгжмийн хэмнэлээр сэгсрээрэй гэж хүүхдэд хэлнэ.

Даалгавар 14	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-3 Модон шоо	Түвшин 2
Агуулга	3 хүртэл модон шоог өрөх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хэд хэдэн жижиг модон шоо		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш эхлээд хэдэн ширхэг модон шоог өрж үзүүлээд хүүхдэд “Дуурайж хийгээрэй” гэж хэлнэ. Өөрөө хийж чадахгүй байвал, багш шоог нэг нэгээр гарт нь өгч өрүүлнэ. 2-3 ширхгийг өрсөн байсан ч магтана.</li> <li>2. Хэд хэдэн удаа давтаж болно. Хүүхэд уйдвал өөр даалгавар хийлгэнэ.</li> </ol>		



Багш шоо өрж байгааг хүүхэд ажиглах



Хүүхэд багшийг дуурайж өрөх

Даалгавар 15	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-3 Модон шоо	Түвшин 3
Агуулга	Модон шоог эвлүүлж ямар нэг дүрс хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хэд хэдэн жижиг модон шоо		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш модон шоог эхлээд дээш нь, хажуу тийш нь өрж үзүүлнэ. Дараа нь 2 модон шоог дундаа зайтай, гүүр мэт дамнуулан дээр нь нэг шоо тавьж үзүүлэн ”Дуурайгаад хийгээрэй” гэж хэлнэ. Багш шоог нэг нэгээр нь хүүхдэд өгнө.</li> <li>2. Дүрсийг сольж хэд хэдэн удаа давтана. Хүүхэд уйдвал өөр даалгавар хийлгэнэ.</li> </ol>		



*Багш хэрхэн шоо өрж байгааг хүүхэд ажиглах*



*Багшийг дуурайж хүүхэд шоог өрөх*

## II-4 Сав болон багаж хэрэгсэл, эд юмс

Даалгавар 16	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-4 Сав болон багаж хэрэгсэл, эд юмс	Түвшин 1
Агуулга	Саванд байгаа эд зүйлийг гаргаж авах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Тагтай, гүнзгий ёроолтой сав, хүүхдийн дуртай тоглоом		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Саванд хүүхдийн дуртай тоглоомыг хийж харуулна. Саван доторх юмсыг гаргуулна. Гараараа эсвэл савыг тонгоруулж гаргаж болно.</li> <li>2. Хүүхэд гаргаж чадвал түүгээр тоглуулна. Саванд өөр зүйл хийгээд дахин хүүхдээр гаргуулна.</li> <li>3. Багшийн саванд хийсэн зүйлийг савнаас нь гаргах явцыг тоглоом болгон хөгжилдөнө. Чадаж байвал хэд хэдэн удаа давтана.</li> </ol>		

16



*Хүүхэд, багшийн саванд хэрхэн хийж,  
буцааж гаргаж байгааг ажиглах*



*Хүүхэд савнаас эд зүйлийг  
гаргаж авах*



Даалгавар 17	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-4 Сав, багаж хэрэгсэл, эд юмс	Түвшин 2
Агуулга	Саванд эд юмс хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хайрцаг, тагтай лааз, хэд хэдэн жижиг эд зүйлс /товч, шүр г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш хүүхдэд саванд юм хийж харуулаад, савыг сэгсэрч дотор нь юм байгаа эсэхийг хамтдаа шалгана.</li> <li>2. Саван доторх юмыг авч хүүхдэд гаргаж өгч, “Буцаагаад саванд нь хийгээрэй” гэж хэлнэ. Хүүхэд саванд хийж чадвал магтана. Дахиад хамтдаа саван дотор нь юм байгааг шалгана.</li> <li>3. Хэд хэдэн өөр эд зүйл хийж, даалгаврыг давтана.</li> </ol>		



Багш савыг сэгсэрч юм байгааг анхааруулж хамтдаа гаргаж авах



Хүүхэд гаргаж авсан юмаа буцааж саванд хийх. Хийж чадвал магтах



### Анхаарах зүйл

Даалгаврыг гүйцэтгэхдээ даалгавар 1-д ашигласан сургалтын хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно.

Даалгавар 18	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-4 Сав, багаж хэрэгсэл, эд юмс	Түвшин 3
Агуулга	Халбага, хавчаар ашиглаж эд юмсыг савнаас гаргах, буцааж хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Том халбага, хавчаар, том товч, жижиг модон шоо, 2 таваг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1 тавган дээр товч болон модон шоо хэд хэдэн ширхэгийг тавина.</li> <li>Хүүхдэд халбага эсвэл хавчаар ашиглаж эд зүйлсийг “Нөгөө таваг руу зөөж хийгээрэй” гэж хэлнэ.</li> <li>Хүүхэд сайн зөөж чадвал магтана. Хэмжээ, хэлбэрийн хувьд хүүхдэд зөөхөд хялбар зүйлүүдийг бэлтгэнэ.</li> </ol>		



*Халбагаар эд зүйлийг нэг тавагнаас нөгөө таваг уруу хийх*



*Хавчаараар хавчин эд зүйлсийг нэг тавагнаас нөгөө таваг уруу хийх*




### **Анхаарах зүйл**

- Гэрийн нөхцөлд нэг тавагнаас нөгөө таваг уруу хоолоо халбагадаж хийх дасгал байнга хийлгэж байхыг гэр бүлд нь зөвлөнө.


## II-5 Цагираг ба уяа

Даалгавар 19	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-5 Шүр ба уяа	Түвшин 1
Агуулга	Уяанд хэлхсэн шүрийг сугалах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хэд хэдэн том шүр, хөндий гоймон, жижиг цагираг, уяа		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Багш шүрийг уяанд хэлхэж үзүүлнэ.</li><li>2. Хүүхдийн өмнө тавьж, “Шүрийг уяанаас нь салгаарай” гэж хэлнэ.</li><li>3. Энэ даалгавар хүүхдэд хүнд байвал багш шүрийг салгаж үзүүлсний дараа дуурайж хийлгүүлнэ. Шүрийг уяанаас салгаж чадвал магтана.</li></ol>		

19



Шүрний нүхээр уяа сүвэлж оруулах



Сүвлэсэн шүрийг уяанаас гаргах

Даалгавар 20	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-5 Шүр ба уяа	Түвшин 2
Агуулга	Том цагирганд бүдүүн уяа сүвлэх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хэд хэдэн том шүр, хөндий гоймон, жижиг цагираг, бүдүүн уяа		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш 3 ширхэг том шүрний нүхээр уяа хэлхэж үзүүлнэ.</li> <li>2. Хүүхдэд нэг гарт нь уяа, нөгөө гарт нь шүр бариулаад, уяанд шүрээ хэлхээрэй гэж хэлнэ.</li> <li>3. Хүүхэд хэлхэж чадвал магтана. Хүүхэд уяанд том шүрээ хэлхэж чадахгүй бол, том цагирагт бүдүүн уяаг сүвлүүлнэ. Хүүхдэд тусалж болох ч аль болох өөрөөр нь хийлгүүлж, дахин давтуулж, олон янзаар оролдох боломж олгоно.</li> </ol>		




*Том хэмжээтэй дүрсний нүхээр  
уяа сүвлэх*



*Хүүхэд даган дуурайж хийх*

Даалгавар 21	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-5 Шүр ба уяа	Түвшин 3
Агуулга	5 ширхэг нүхтэй дүрсийг уяанд хэлхэх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	5 ширхэг нүхтэй дүрс /модон дүрс, хөндий гоймон, жижиг цагираг, том шүр/, уяа		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш 3 ширхэг том шүрийг уяанд хэлхэж үзүүлээд, хүүхдэд нүхтэй дүрсийг уяанд хэлхээрэй гэж хэлнэ. Хүүхэд хэлхэж чадвал магтана. Дараа нь тоог нэмж 5 хүртэлх тооны нүхтэй дүрс хэлхүүлнэ.</li> <li>2. Багш өөр өөр хэмжээтэй дүрсийг хэлхэж үзүүлнэ. Нүхтэй дүрсийг үдээсэнд том-жижиг-том-жижиг дарааллаар хэлхээрэй гэж хүүхдэд хэлнэ.</li> <li>3. Хүүхдийн хэлхэснийг багшийн хэлхэсэнтэй харьцуулж, адилхан болсон эсэх, юу нь өөр байгааг анхааралтай харуулж, тайлбарлана. Шаардлагатай тохиолдолд дахин нэг удаа давтан хийлгэнэ.</li> </ol>		



*Багш янз бүрийн хэлбэртэй нүхтэй дүрс хэлхэж хүүхдэд харуулах*



*Багшийн хийснийг хүүхэд дуурайж хийх*

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

Нүхтэй дүрс ба уяа ашиглан хийх даалгавар

- Зургийн хичээл дээр шүр ашиглан бүтээл хийлгэхдээ тухайн хүүхдийн бодит байдал, чадварыг харгалзан хамтдаа бүтээл хийх замаар хүүхэд бүрийн оролцоог дэмжих сургалтыг зохион байгуулна. Хүүхдийн бүтээлийг ангийн хананд өлгөх, ангиа чимэглэх, бүтээлийн самбарт байрлуулах зэргээр ашиглавал хүүхдийн бүтээлч сонирхол нэмэгдэнэ.
- Хөдөлгөөн, үйл ажиллагаа айн хэсэгт өгөгдсөн даалгаврын хүрээнд хайч, цавуу ашиглан цаасаар цагираг хийж наах, гинжлэн холбох даалгавар хийлгэнэ.
- Хүүхдэд янз бүрийн өнгө, дүрс, хэмжээтэй зүйлийн загварыг харуулж, бүтээл хийлгэн дадлагажуулна.

## II-6 Цахилгаан, товч, цаас

Даалгавар 22	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-6 Цахилгаан, товч, цаас	Түвшин 2
Агуулга	Уутны амны цахилгааныг нээх, хаах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Том цахилгаантай уут, хүүхдийн дуртай эд юмс /модон шоо, өнгө өнгийн дүрс, бал, машин г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Цахилгаантай уутанд модон шоо, өнгө өнгийн дүрс гэх мэт зүйлийг хийж тавина.</li> <li>2. Хүүхдийн гарт уутыг бариулж, дотор нь байгаа юмыг тэмтэрч мэдрүүлнэ. Уутны цахилгааныг нээж, дотор нь байгаа зүйлийг гаргуулна.</li> <li>3. Хүүхэд уутнаас модон шоо, өнгө өнгийн дүрс гэх мэт зүйлийг гаргаж чадвал тухайн шоо, дүрсээр ямар нэг зүйл хийлгэнэ. Дараа нь ашигласан модон шоо, дүрсийг уутанд буцааж хийлгэн, цахилгаандуулна.</li> <li>4. Гутал, хувцас, цүнхний цахилгааныг тайлах, татах үйлдлийг хүүхэд бие дааж хийж чаддаг болгоно.</li> </ol>		

22



Уутны цахилгааныг нээж, доторх эд юмыг гаргах



Уутанд эд юмыг буцаан хийж, цахилгааныг татах

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

Хүүхэд цахилгаантай хувцас их өмсдөг. Цахилгааны татуурга нь гарт амар баригдахгүй тул татуурганд уяа уяж, уртасган татахад хялбар болгоно.

Даалгавар 23	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-6 Цахилгаан, товч, цаас	Түвшин 3
Агуулга	Том товч тайлах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Том товчтой уут, хүүхдийн дуртай зүйл /модон шоо, өнгө өнгийн дүрс, бал, машин, хүүхэдэй г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Уутанд хүүхдийн дуртай зүйлээс хийж товчлон хаана.</li> <li>2. Хүүхдээр дотор нь байгаа зүйлийг тэмтрүүлж, мэдрүүлнэ. Уутны товчийг тайлж, доторх зүйлийг гаргуулна.</li> <li>3. Уутнаас гаргасан зүйлээр тоглуулна. Дараа нь уутанд буцааж хийнэ. /Товч товчлох үйлдлийг багш хийж болно/</li> </ol> <ol style="list-style-type: none"> <li>1. Хувцасны товчоо хүүхэд өөрөө тайлдаг болгоно.</li> </ol>		



*Уутанд юу байгааг тэмтэрч мэдрэх*



*Уутны товчийг нь тайлж, доторх зүйлийг гаргах*

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- Хүүхэд өөрөө хувцас, цүнхний товчоо тайлах, товчлох үйлдлийг өдөр бүр хийх боломжтой. Хүүхдэд хувцас сонгохдоо хүүхдийн хөгжлийн үе шатыг дэмжих үүднээс товчны хэмжээг бодолцох хэрэгтэй.
- Даавуун цүнх, уут хийхдээ хүүхдийн бодит байдлыг бодолцон, товчны нүхний байрлал /хэвтээ, босоо/ болон товчийг хэт нааж оёхгүй байх хэрэгтэй. Хүүхэд багахан чармайлт гаргаад өөрөө товчоо товчилж, тайлж чадаж байхаар хийнэ.

Даалгавар 24	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-6 Цахилгаан, товч, цаас	Түвшин 5
Агуулга	Цаасыг дундуур нь нугалан дугтуйд хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Бичгийн цаас, дугтуй		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Цаасан дээр дуртайгаараа зураг, дүрс зурж, үсэг бичнэ.</li> <li>2. Багш цаасыг дундуур нь нугалж үзүүлээд, хүүхдээр дуурайлган хийлгэнэ. Хүүхэд эхлээд цэвэрхэн зөв нугалж чадахгүй байсан ч сураад ирэхээр нь цаасны 2 үзүүрийг тэнцүүлж нугалуулна.</li> <li>3. Цаасыг дундуур нь нугалсны дараа дугтуйд хийлгэнэ.</li> </ol>		



*Хүүхэд цаасыг дундуур нь нугалах*



*Нугалсан цаасаа дугтуйд хийх*



## II-7 Модон дүрсийг “Пэг” тоглоомын сууринд хийх

Даалгавар 25	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-7 Модон тоглоом хэвэнд хийх хэрэглэгдэхүүн	Түвшин 1
Агуулга	"Пэг" тоглоомын сууринаас модон дүрсээ сугалж авах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	“Пэг” тоглоом		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. “Пэг” тоглоомын сууринд дүрсийг хийж үзүүлнэ.</li><li>2. Дараа нь хүүхдээр “Пэг” сууринаас дүрсийг гаргуулна.</li><li>3. Хүүхэд сууринаас гаргаж чадвал магтана.</li></ol>		

25



“Пэг” тоглоомын сууринд дүрсийг хийж үзүүлэх



Хүүхэд “Пэг” тоглоомын сууринаас дүрсээ гаргах

Даалгавар 26	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-7 Модон тоглоом хэвэнд хийх хэрэглэгдэхүүн	Түвшин 2
Агуулга	"Пэг" сууринд модон дүрсээ хийх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	“Пэг” тоглоом		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш хүүхдэд 1 ширхэг модон дүрсийг өгч, "Пэг" сууринд хийлгэнэ.</li> <li>2. Хүүхэд “Пэг” сууринд хийж чадаж байвал хэд хэдэн модон дүрсийг ”Пэг” сууринд хийлгэнэ.</li> <li>3. Хүүхэд “Пэг” сууринд бүгдийг нь хийж чадвал магтана.</li> </ol>		



*Том наалтыг хүрээн дотор наах*



*Жижиг наалтыг хүрээн дотор наах*

Даалгавар 27	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-7 Модон тоглоом хэвэнд хийх хэрэглэгдэхүүн	Түвшин 3
Агуулга	Хүрээ хязгаар дотор наалт наах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Наалтан цаас		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш урьдчилан наалтны хэмжээнд тохируулан цаасан дээр хүрээ зурж бэлдэнэ.</li> <li>2. Наалтнаас нэгийг хүрээн дотор нааж үзүүлээд, хүүхдээр дуурайлган хийлгэнэ.</li> <li>3. Хүүхдийн түвшинд тохируулан хүрээг том, жижиг хэмжээтэйгээр зурж, том, жижиг наалт бэлдэнэ. Хүүхэд нааж чадвал магтана.</li> </ol>		

27

#### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- Өдөр бүр хичээл эхлэхийн өмнө ирцийн карт дээр он, сар, өдрийн наалтыг наалгаж, он, сар, өдрийн тухай ойлгуулах, сургуульд явах хүсэл эрмэлзэлтэй болгохыг зорино.
- Тоо тоолол заах үед бэлдсэн хүснэгтэд наалт наах үйлдлийг хийлгэх, тоолуулах зэрэг дасгал хийлгэнэ. Тоо хэмжээтэй холбон тайлбарлан заах нь зохимжтой.

## II-8 Үйл ажиллагаа

Даалгавар 28	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-8 Үйл ажиллагаа	Түвшин 2
Агуулга	Цаасан дүрсээ цавуудаж хүрээнд наах		
Орчин	Наамалын хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цавуу, дүрс, зургийн дэвтэр, ватум цаас		
Дараалал	<ul style="list-style-type: none"> <li>• Дүрсэн дээрээ цавуу түрхэж, тухайн дүрсээ зургийн дэвтэр болон ватум цаасан дээр наалгана. Хийж чадвал магтана.</li> <li>• Багш хүүхдийн чадвар, сонирхолд нь нийцүүлэн, хүүхдэд танил зүйлийн дүрсийг 1/ Машин, цэцэгний дүрсийг хайчилж бэлдээд наах, 2/ Машины дугуй, цэцэгний дэлбээ зэргийг зөв байрлуулан наах, 3/ Хүрээ татаж дунд нь дүрсээ наах зэргээр зорилт тавьж ажиллана.</li> </ul>		

28



Дүрсээ цавуудах



Цавуудсан дүрсээ хүрээнд наах

### БУСАД ТОХИОЛДОЛД ХЭРЭГЛЭХ АРГА ЗҮЙН САНАА

- Зургийн хичээл дээр энэхүү даалгаврыг хийвэл тохиромжтой. Дуртай дүрсээ хайчаар хайчлах, цавуугаар наах үйл ажиллагаагаар дамжуулан хүүхдэд сонирхолтой байж, хийсэн бүтээл нь гоё сайхан гэж мэдрүүлэхээр бэлтгэнэ.
- Бусад хичээлийн цагаар цаас, тараах материал зэргийг дэвтэртээ наах даалгавар өгч болно.



#### Анхаарах зүйл

- Цавуу нь түрхэгдсэн эсэх нь ойлгомжтой байхыг бодолцож, шингэн цавуунд усан будаг хийж холиод өнгөтэй болгож бэлтгэнэ. Шингэн цавуу ашиглахад хүндрэлтэй байгаа хүүхдэд харандаан цавуу бэлтгэнэ.

Даалгавар 29	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-8 Үйл ажиллагаа	Түвшин 4
Агуулга	Шулуун болон муруйг зураасын дагуу хайчлах		
Орчин	Дүрслэх урлаг, технологи болон ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Шулуун, муруй зураас зурсан цаас, хайч		
Дараалал	<ul style="list-style-type: none"><li>• Хүүхдэд хайч, шулуун болон муруй зураас зурсан цаасыг өгч, зураасны дагуу хайчлаарай гэж хэлнэ.</li><li>• Зурааснаас илүү гарсан ч зөв хайчлахыг хичээж байвал сайн.</li><li>• Хайчилсан дүрсийг нь хүүхдэд харуулж магтана.</li></ul>		

29



*Цаасыг зураасны дагуу хайчлах*



### **Анхаарах зүйл**

- Хайчны хэмжээ, барихад эвтэй эсэх, хайчтай ажиллах үеийн аюулгүй байдлыг анхаарна. Нэг удаагийн үйлдлээр хайчилж дуусгаж болох зүйлийг хайчилж, хайчлах үйлдлийг эзэмшүүлнэ.

Даалгавар 30	II Хөдөлгөөн, үйл ажиллагаа	II-8 Үйл ажиллагаа	Түвшин 5
Агуулга	Муруй зураасыг болон өнцөг гаргаж өөгүй хайчлах		
Орчин	Дүрслэх урлаг, технологи болон ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Муруй зураас, дөрвөлжин, гурвалжин дүрсийг том зурсан цаас, хайч		
Дараалал	<ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд муруй зураасыг зурсан цаас өгч, зураасын дагуу хайчлаарай гэж хэлээд хайч өгнө.</li> <li>• Зурааснаас хазайсан ч зураасны дагуу зөв хайчлахын тулд анхаарч, мэрийж байвал болно.</li> <li>• Хайчилсан дүрсийг нь хүүхдэд харуулаад магтана.</li> </ul>		

30



*Зураасны дагуу гурвалжин дүрсийг хайчлах*

### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

Өнгийн цаас ашиглаж, зураасны дагуу хайчлах, цавуугаар наах, цагирган чимэглэл хийх зэргээр хүүхдэд сонирхолтой байхаар хийлгэнэ /урт, богино, бүдүүн нарийн нь харилцан адилгүй цагирган чимэглэл хийх нь хүүхдэд сонирхолтой байдаг/.

30





## ХЭЛ ЯРИА, ТАНИН МЭДЭХҮЙ, ТОО ТООЛОЛ

### III-1 Дүрс, өнгө болон эд юмсыг зориулалтаар нь нийлүүлэх, ялгах

Даалгавар 31	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, өнгөөр болон зориулалтаар нь III-1 ангилах	Түвшин 2
Агуулга	Ижил зүйлүүдийг нэгтгэх, ангилах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	2 ш таваг, ижил өнгө, дүрстэй 2ш зүйл /шагай, модон шоо, урт савх, товч г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Таваг дээр 1,1 ялгаатай зүйл тавина. Нөгөө ижлийг нь тавагны гадна сул тавина.</li> <li>2. Хүүхдээр ижлийг сонгуулж тавганд хийлгэнэ.</li> <li>3. Хүүхэд хийж чадвал магтана. “Ижил” гэсэн үгийн утгыг тайлбарлана. Үүний дараа хэрэглэгдэхүүнээ сольж үргэлжлүүлэн хийж болно. <ol style="list-style-type: none"> <li>1. Хэрвээ хүүхэд даалгавар хэцүү байвал ширээн дээр байгаа зүйлүүдийн тоог багасгана.</li> <li>4. Дээрх даалгаврыг хийж чадвал 4 зүйлийг тавагны гадна тавьж, ижлээр нь тавганд ялгаж хийлгэнэ. /Ялган таних/</li> </ol> </li> </ol>		

31



Таваг дээр 1,1 ялгаатай зүйл тавина.  
Нөгөө ижлийг нь тавагны гадна сул тавих



Хүүхэд тавганд ижилсүүлэн ялгаж хийх

#### Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа

- Даалгавар гүйцэтгэх хүүхдийн гарт 3 өөр төрлийн хэрэглэгдэхүүн /товч, модон шоо, савх/ бариулна. Ангийн 3 найзад нь эдгээр хэрэглэгдэхүүнийг нэг нэгээр бариулна. Найзынхаа гарт байгаа зүйлийн ижлийг олж өгнө. Энэ даалгаврыг математикийн хичээл дээр тоо тооллын үед ашиглаж болно.
- Хүүхдийн эд зүйл дээр таних тэмдэг тавьсан байна. Хүүхэд тэдгээрийг ашиглах үедээ өөрийн таних тэмдгийг харж тавьсан тэмдгүүд ижил байгааг давтан хэлж, хэрэглэнэ.



Даалгавар 32	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, III-1 өнгөөр болон зориулалтаар нь ангилах	Түвшин 2
Агуулга	Ижил зургуудыг нэгтгэх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	2 таваг, зурагт картууд хосоороо		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Таваг дээр 1,1 ялгаатай зурагт карт тавина. Нөгөө ижлийг нь тавагны гадна сул тавина.</li> <li>2. Хүүхдээр ижлийг сонгуулж тавганд хийлгэнэ.</li> <li>3. Хүүхэд хийж чадвал магтана. “Ижил” гэсэн үгийн утгыг тайлбарлана. Үүний дараа хэрэглэгдэхүүнээ сольж үргэлжлүүлэн хийж болно. Хэрвээ хүүхдэд хэцүү байвал ширээн дээр тавьсан зурагт картын тоог багасгана.</li> <li>4. Дээрх даалгаврыг хийж чадвал 4 зурагт картыг тавагны гадна тавьж, ижлээр нь тавганд ялгаж хийлгэнэ. /Ялган таних/</li> </ol>		



Тавганд 1,1 ялгаатай зурагт карт тавина.  
Нөгөө ижлийг нь тавагны гадна тавих



Хүүхдээр ижлийг нь олуулж  
тавганд ялгаж тавиулах



*Багш магтангаа дүрсийг харуулж "Ижил байна, тийм үү" гэж нягтлах*



*Хүүхэд ижил дүрсийг нэг тавганд хийх /ангилах арга/*

### **Бусад тохиолдолд хэрэглэх арга зүйн санаа**

- Хүүхдийн дуртай зүйлээс сонгож, таних тэмдэг болгон авна. Таних тэмдгийг өөрийнх нь тавиур болон авч явдаг эд юмс дээр нааж, хурааж цэвэрлэх үед нь ашиглуулна. Эхлээд таних тэмдгийн хэмжээ ижил байна. Хэрэглэж дасаад ирэхээр нь таних тэмдгийн хэмжээг өөрчилж болно.

### **Бодит жишээ**

- Хөзрийн мод нийлүүлэх зарчмаар, бунд, дөрвөлжин, цэцэг, гил хөзрүүдээс нэг нэгийг дэлгэж тавина. Газрын модноос сөхөж тохирох дүрс дээр нийлүүлж тавина.
- Хөзөрнөөс гадна өнгө, дүрс нийлүүлэх ямар ч тоглоомыг ашиглаж болно.

Даалгавар <b>33</b>	Хэл яриа, <b>III</b> танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, <b>III-1</b> өнгөөр болон зориулалтаар нь ангилах	Түвшин 2
Агуулга	Өнгөөр нь ижилсүүлж ангилах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	2 таваг, ижил өнгийн картууд /улаан, хөх, шар г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. 2 тавганд өөр өөр өнгийн карт хийнэ.</li> <li>2. “Ижил өнгийг олж хийгээрэй” гэж хэлнэ. Хийж чадвал магтана. “Улаан-Улаан ижил өнгөтэй байна” гэж хэлнэ.</li> <li>3. Дээрх даалгаврыг хийж чадвал өнгийн картуудыг тавагны гадна тавьж, ижлээр нь тавганд ялгаж хийлгэнэ. /Ялган таних/.</li> </ol>		



*Ижил өнгийг тааруулж тавган дээр тавих*



*Картуудыг ижил өнгөөр ялгаж тавих*

Даалгавар 34	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, өнгөөр болон III-1 зориулалтаар нь ангилах	Түвшин 3
Агуулга	Хэлбэрээр нь ижилсүүлж нэгтгэх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	3 таваг, дугуй, гурвалжин, дөрвөлжин дүрс тус бүр 5ш		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. 3 тавганд өөр өөр дүрс хийнэ.</li> <li>2. Хүүхдээр ижил дүрсийг сонгуулж, тавганд хийлгүүлнэ.</li> <li>3. Хийж чадвал “ижил” гэдэг үгийг тайлбарлана. Дахин өөр дүрс ширээн дээр тавьж, даалгаврыг давтан хийлгэнэ.</li> </ol>		



Таваг дээр тавьсан дүрсүүдийн ижлийг олуулах



Багш магтангаа дүрсийг харуулж “Ижил байна, тийм үү” гэж нягтлах



### Анхаарах зүйл

1. Эхний түвшинд картуудын өнгө нь ижил байна.
2. Түвшин ахих бүрд картны өнгийг сольж, дүрс таних даалгавар өгснөөр танин мэдэх чадварыг нэмэгдүүлнэ.

Даалгавар 35	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-1 Эд юмсыг дүрсээр, өнгөөр болон зориулалтаар нь ангилах	Түвшин 3
Агуулга	Зургаар үзүүлсэн эд зүйлийг олох		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Зурагт карт, бодит зүйл /халбага, товч, модон шоо г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>3 өөр зурагтай картыг тавина. Хүүхдэд бодит зүйлээс 1 ширхгийг өгч “Аль зурагтай ижил байна вэ?” гэж асууж, ижил зураг дээр нь тавиулна.</li> <li>Хийж чадвал “Ижилхэн байна тийм үү” гэж хэлээд магтана. Өөр зурагт картыг тавьж дээрхтэй адил гүйцэтгүүлнэ.</li> </ol>		

35



*Багш зургийг тавагны урд тавьж,  
бодит зүйлийг хүүхдэд өгөх*



*Хүүхэд авсан зүйлээ ижил  
зурагтай тавганд хийх*

### Жишээ

- Бал тавих хэсэгт балны зураг наах зэргээр өөрийн цүнх, хувцас тавих газарт таних тэмдгийг нааж, хурааж цэвэрлэх үеэр ашиглуулна.
- Тоглоом, багаж хэрэгсэл ашиглах хичээл дээр тухайн зүйлийн зурагт картыг бэлтгэн бодит зүйлийг олуулна.

Даалгавар 36	Хэл яриа, Ш танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, Өнгөөр болон Ш-1 зориулалтаар нь ангилах	Түвшин 3
Агуулга	Эд зүйлийг өнгөөр нь ангилах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	2 өнгийн 4 ширхэг зүйл /модон шоо, харандаа, өнгийн карт г.м/ Таваг 2 ширхэг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>2 тавагт өөр өнгөтэй ижил зүйл нэг нэгийг тавина. Ижилсүүлэх өнгийн эд зүйлийг нь тавагны гадна тавина.</li> <li>Хүүхдэд өнгөөр нь ижилсүүлж таваг дээр тавих даалгавар өгнө. Чадвал “Ижил өнгөтэй байна, тийм үү” гэж хэлээд магтана. Өөр хэрэглэгдэхүүнээр сольж мөн адил гүйцэтгүүлнэ.</li> <li>Ширээн дээр 2 хоосон таваг тавьж, гадна талд нь 2 өнгөнд ижилсүүлэх боломжтой зүйлийг замбараагүй тавина. Өнгөөр нь ижилсүүлж тавганд хийлгэнэ. Чадаж байвал магтана. Өөр хэрэглэгдэхүүн ашиглаж болно. <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдэд хэцүү байвал 1-ээр алхам руу буцаж, тавганд нэг нэгийг тавьж дэмжлэг үзүүлнэ.</li> </ul> </li> </ol>		



2 тавагт өөр өнгөтэй ижил зүйл нэг нэгийг тавина. Хосыг нь тавагны гадна тавих



Өнгөөр ижилсүүлж тавих /шоо болон өнгийн карт/

### Жишээ

- Асран хамгаалагчийн тусламжтай нэг өнгөөр /тод шар, улаан, хөх/ хийсэн хос бээлий бэлтгэнэ. Өдөр тутам бээлий өмсөж тайлах үед өнгийг хэлүүлж, “Ижил өнгөтэй байна” гэж өнгөний тухай ойлголтыг өгч, хэвшүүлнэ.
- Хүүхэд ойлгоод ирэхээр нь бээлийний өрөөснийг олуулна. /Оймс, гутал г.м/

Даалгавар <b>37</b>	Хэл яриа, <b>III</b> танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, өнгөөр болон <b>III-1</b> зориулалтаар нь ангилах	Түвшин 4
Агуулга	Эд зүйлийг хэлбэр дүрсээр ангилах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Таваг 3 ш Дүрс тус бүр 5 ш /гурвалжин, дөрвөлжин, дугуй/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>3 тавагны гадна дүрсүүдээ эмх замбараагүй тавина. /тавганд юу ч хийхгүй/</li> <li>Хүүхэд ижил дүрсүүдийг олж, хос хосоор нь тавганд хийнэ. Хийж чадвал магтана.</li> </ol>		

37



*3 тавагны гадна дүрсүүдээ эмх замбараагүй тавина. /тавганд юу ч хийхгүй/*



*Хүүхэд ижил дүрсүүдийг олж, хос хосоор нь тавганд хийнэ. Хийж чадвал магтана.*



### Анхаарах зүйл

1. Эхлээд дүрсний өнгийг ижилсүүлнэ.
2. Дүрсний өнгийг өөрчлөх замаар хэлбэр дүрсний тухай ойлголтыг тодорхой болгож өгнө.

Даалгавар 38	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-1	Эд юмсыг дүрсээр, өнгөөр болон зориулалтаар нь ангилах	Түвшин 4
Агуулга	Эд зүйлийг зориулалтаар нь ангилах			
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Хэрэглэгдэхүүн	Өнгө, хэлбэр дүрс, хэмжээгээрээ ялгаатай эд зүйл /халбага, харандаа, товч, шоо г.м/, таваг 2-3ш			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. 2 тавагны гадна халбага, харандаа хэд хэдийг эмх замбараагүй тавина.</li> <li>2. “Ижил ижлээр нь нэг тавганд хийгээрэй” гэж хэлнэ. Хийж чадвал магтана. “Энэ бол халбага, энэ бол харандаа” гэж хэлээд яагаад ижил төрөл болохыг хэлж тайлбарлана. <ol style="list-style-type: none"> <li>1. Даалгавар хүнд байвал “Халбага нь аль вэ?” зэргээр дөхүүлэх асуулт асууна.</li> </ol> </li> <li>3. Чадаж байвал түвшин ахиулж 3 тавганд хийлгэнэ.</li> </ol>			



2 тавагны гадна халбага, харандаа хэд хэдийг эмх замбараагүй тавих



Ижил ижлээр нь нэг тавганд хийлгэх



Даалгавар 39	Хэл яриа, Ш танин мэдэхүй, тоо тоолол	Эд юмсыг дүрсээр, Ш-1 өнгөөр болон зориулалтаар нь ангилах	Түвшин 4
Агуулга	Эд зүйлсийг зориулалтаар нь ангилах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Халбага, сэрээ, харандаа, бал, оймс, бээлий /бодит зүйл болон зурагт карт/, Таваг 2-3ш		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>2 тавагны гадна халбага, сэрээ, харандаа, бал замбараагүй тавина.</li> <li>Хүүхдэд “Ижил ижлээр нь тавганд хийгээрэй” гэж хэлнэ. Хийж чадвал магтаад “Халбагаар иднэ, сэрээгээр иднэ”, “харандаагаар бичнэ, балаар бичнэ” зэргээр зөв хийж байгааг батлан тайлбарлана. <ol style="list-style-type: none"> <li>Даалгавар хүнд байвал “Юугаар иддэг билээ?” гэх зэргээр дөхүүлэх асуулт асууна.</li> </ol> </li> <li>Хэрэглэгдэхүүнээ солиод, тавагны тоог нэмж болно.</li> </ol>		



*Багш ширээн дээр ижил зориулалттай зүйлс тавих /халбага сэрээ, бал харандаа/*



*“Ижил ижлээр нь тавганд хийгээрэй” гэж хэлээд чадвал магтаад “Халбагаар иднэ, сэрээгээр иднэ”, “харандаагаар бичнэ, балаар бичнэ” зэргээр зөв хийж байгааг тайлбарлах*



### Анхаарах зүйл

- Хүүхдэд өдөр тутам янз бүрийн эд зүйлтэй харьцах боломж өгч “ижил байна” “нэг төрөл байна” гэдэг ойлголтыг өгч байна.

### Жишээ

Зурагт картыг ашиглан төрлөөр нь ангилах тоглоом тоглуулна. Зурагт карт дээр зориулалтыг нь хараад ойлгохоор аль нэг өнцөгт нь тэмдэг тавиад /Жишээлбэл: Халбага, сэрээ зэрэг хоолны хэрэгсэл байвал картны өнцөг дээр нь таваг, аяганы зураг зурсан байх/ эхлээд тухайн тэмдгээр олуулна. Тоглонгоо ..... учир нэг төрөл гэж хэлээд агуулгыг ойлгуулна.

## III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих

Даалгавар 40	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 2
Агуулга	Өөрийн дураар сараачиж зурах		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, эсгий бал, өнгийн харандаа		
Дараалал	<ol style="list-style-type: none"><li>1. Багш сараачиж зурж үзүүлээд хүүхдэд “Юу ч хамаагүй зураарай” гэж хэлнэ.</li><li>2. Хүүхэд ямар нэг зүйл зурж чадвал магтаад түвшин 3 руу шилжинэ.</li></ol>		



*Хүүхэд өөрийн дураар сараачих*



### **Анхаарах зүйл**

- Төрөл бүрийн өнгийн харандаа бэлдэнэ. Хүүхдийн гарт эвтэйхэн, зурахад хүч шаардахгүй, бүдүүн үзүүртэй байвал сайн.
- Бусдын эд зүйл дээр хамаагүй сараачиж зуруулахгүйн тулд зааварчилгааг сайн өгнө.

Даалгавар 41	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 3
Агуулга	Хөндлөн, босоо зураасыг дуурайж зурах		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, эсгий бал, өнгийн харандаа г.м		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш босоо зураасыг 2 удаа зурж үзүүлээд, хүүхдэд “Дуурайгаад зураарай” гэж хэлнэ.</li> <li>2. Хүүхэд зураасыг зурж чадвал магтана. Дараа нь хөндлөн зураасыг зуруулна.</li> </ol>		

41



*Хүүхэд дуурайж зурах*



### **Анхаарах зүйл**

Багш эхлээд хүүхдийн гарыг барьж хөдөлгөөнийг чиглүүлж дэмжин зуруулж, аажмаар бие даалгана.

Даалгавар 42	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 3
Агуулга	Дугуй дүрс дуурайж зурах		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, эсгий бал, өнгийн харандаа г.м		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Дугуй дүрсийг зурж үзүүлээд, “Дуурайгаад зураарай” гэж хүүхдэд хэлнэ.</li> <li>2. Хүүхэд дугуй дүрс зурж чадвал магтана. Багш хүүхэд хоёр хамтдаа дугуй дүрс зурна.</li> </ol>		



*Багш дугуй дүрс зурж үзүүлэх*



*Хүүхэд багшийг дуурайж дугуй дүрс зурах*




**Анхаарах зүйл**

Дугуй дүрс зурахын өмнө дугуй дүрс бүхий дардас ашиглаж тоглуулна.

Даалгавар 43	Хэл яриа, танин III мэдэхүй, тоо тоолол	Зураг дүрс III-2 зурах, үсэг бичих	Түвшин 4
Агуулга	Нэмэх тэмдэг, дөрвөлжин дүрс, ташуу зураасыг дуурайж зурах		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, эсгий бал, өнгийн харандаа г.м		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш нэмэх тэмдэг зурж үзүүлээд “Дуурайгаад зураарай” гэж хүүхдэд хэлнэ.</li> <li>2. Хүүхэд түүнийг зурж чадвал магтана. Дээрх маягаар дөрвөлжин, ташуу зураасыг зуруулна.</li> <li>3. Эдгээрийг зурж чадвал нэмэх, дөрвөлжин, ташуу зураас бүхий зурагт картыг үзүүлж, дуурайж зурах даалгавар өгнө.</li> </ol>		

43



Багш нэмэх тэмдэг зурж үзүүлэх



Хүүхэд дуурайж нэмэх тэмдэг зурах



### Анхаарах зүйл



1. Хүүхэд бичих үед багш гараас нь барьж дэмжлэг үзүүлнэ.
2. Багш эхлэх болон дуусах цэгийг зааж өгч, цэгэн зураасыг давхарлан бичүүлнэ.
3. Нэмэх тэмдэг, дөрвөлжин, ташуу зураасыг зуруулахын тулд хүүхдэд зурах чиглэл, хэлбэрийг заасан хүрээ бэлдэж өгнө.

Даалгавар 44	Хэл яриа, Ш танин мэдэхүй, тоо тоолол	Ш-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 4
Агуулга	Шулуун болон нуман зураасыг балаар давхарлаж зурах		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, харандаа, бал г.м		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Эхлээд багш шулуун болон нуман зураасыг зурж үзүүлээд, давхарлаж зуруулна.</li> <li>2. Хүүхэд чадвал магтана. Багш хүүхэд хамтдаа давхарлан зурж тоглох бөгөөд аажмаар түвшинг хүндрүүлнэ.</li> </ol>		



*Багш муруй, шулуун шугам зурж үзүүлэх*




*Хүүхэд дуурайж зурах*

Даалгавар 45	Хэл яриа, танин III мэдэхүй, тоо тоолол	III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 5
Агуулга	Гурвалжин дүрс болон хялбар үсгийг давхарлаж бичих		
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цаас, харандаа, бал г.м		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Гурвалжин дүрсийг зурж үзүүлээд, давхарлаж зуруулна.</li> <li>2. Хүүхэд чадвал магтана. Багш хүүхэдтэй хамт давхарлаж бичиж тоглонгоо хялбар үсэг бичүүлнэ.</li> </ol>		

45



*Гурвалжин дүрс зурж үзүүлэх*



*Хүүхэд багшийн адилаар гурвалжин дүрс зурах*



### **Анхаарах зүйл**

1. Хүүхэд бичиж, зурахад хялбар даалгавар өгнө.
2. Гурвалжин дүрсний хэв бэлдэж, хэвэн дотор харандаагаар зуруулна
3. Цэг холбож гурвалжин дүрс зуруулна.

Даалгавар 46	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-2	Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 5
Агуулга	Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрс, хялбар үсгийг балаар давхарлаж бичих			
Орчин	Дүрслэх урлаг, Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Хэрэглэгдэхүүн	Цаас, харандаа, бал г.м			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Гурвалжин дүрс зурж үзүүлээд хүүхдэд “Дуурайгаад зураарай” гэж хэлнэ.</li> <li>2. Чадвал магтана. Дараа нь багш хялбар үсэг бичиж үзүүлээд хүүхдээр дуурайлгаж бичүүлнэ.</li> <li>3. Хүүхэд дээрх 2 даалгаврыг хийж чадвал гурвалжин дүрс, үсэг бичсэн карт үзүүлээд, дуурайж бичих даалгавар өгнө.</li> </ol>			



Багш нарийн үзүүртэй балаар дөрвөлжин дүрс зурж үзүүлэх



Хүүхэд эсгий балаар давхарлаж зурах



### Анхаарах зүйл

- Багш хүүхдэд ойлгомжтой харагдахаар бичнэ. Хүүхдэд давхарлан бичихэд тохиромжтой, гарт барихад эвтэйхэн эсгий бал өгнө.
- Эхлэх болон дуусах цэгийг зааж өгч, давхарлан бичих хэсгийг хургуугаараа чиглүүлэн зааварчилж бичүүлнэ. Бичих явцад урамшуулна.



### III-3 Үсэг унших

Даалгавар 47	Хэл яриа, III танин мэдэхүй, тоо тоолол	III-2 Зураг дүрс зурах, үсэг бичих	Түвшин 4
Агуулга	Өөрийн нэрэнд ордог үсгээ олох		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Хүүхдийн нэрний үсэг орсон ижил 2ш карт		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Ширээн дээр хэд хэдэн үсэг бичсэн картыг эгнүүлж тавина.</li> <li>2. Багш үсэг бичсэн картнаас нэгийг авч ширээн дээр тавьж, ижил үсэгтэй картыг хүүхдээр олуулна.</li> <li>3. Хүүхэд зөв сонгож чадвал тухайн үсгийг уншиж үзүүлнэ.</li> <li>4. Өөр үсэгтэй картыг мөн аргаар олуулна.</li> </ol>		

47



Багш ширээн дээр өөр өөр үсэгтэй хэд хэдэн карт тавих



Хүүхдийн нэрэнд орсон үсгийг үзүүлэн ижил үсгийг олуулах



#### Анхаарах зүйл

- Хүүхдийн хувцас болон эд зүйлд нь нэрийг бичиж өгнө. Нэрний хажууд нь таних тэмдгийг тэмдэглэж болно. Хүүхэд эд зүйлийг хэрэглэх үед нь тухайн хүүхдийн нэрийг хэлж хэнд хамаарах, хэний эд зүйл болохыг ойлгуулна.
- Сургууль дээр ирц бүртгэх, хүүхдийн бүтээлийг самбарт байрлуулах үед хүүхдийн нэрийг нь бичсэн карт ашиглан хэний бүтээл болохыг ялган нэрлэж чаддаг болгоно. Ингэснээр найз нараа нэрлэж хэвшинэ.

Даалгавар 48	Хэл яриа, танин III мэдэхүй, тоо тоолол	III-3 Үсэг унших	Түвшин 5
Агуулга	Өөрийн нэрийн бүх үсгийг олох		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Цагаан толгойн хэрчмэл үсгэн карт /2 багц/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Ширээн дээр хэд хэдэн ялгаатай үсэг бичсэн картыг эгнүүлж тавина.</li> <li>2. Багш үсэг бичсэн карт нэгийг ширээн дээр тавьж, хүүхдээр ижил үсэг бичсэн карт олуулна. Хүүхэд зөв олж чадвал тухайн үсгийг хэлж өгнө. Бусад үсэг бичсэн картыг мөн адилаар олуулна.</li> <li>3. Багш "... үсэг аль вэ?" гэж асуун хүүхдээр олуулна. Хүүхдэд энэ даалгавар хүнд байвал өөр үсэг бичсэн карт үзүүлж, ижил үсэгтэй картыг олуулна.</li> </ol>		



*Багш өөр өөр үсэг бичсэн картыг зэрэгцүүлж тавих*



*Багш хүүхдийн нэрэнд орсон үсэг бичсэн картыг харуулж, ижил үсэгтэй картыг олуулах*

### Жишээ

Үгт ба зурагт картыг харгалзуулах тоглоом тоглож болно.

Даалгавар 49	Хэл яриа, танин III мэдэхүй, тоо тоолол	III-3 Үсэг унших	Түвшин 5
Агуулга	Бүх тоог олох		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	1-9 хүртэл цифр бичсэн карт /2 багц/ 1-9 хүртэл тоог дүрсээр илэрхийлсэн карт		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1-3 хүртэл тоо бүхий картыг эгнүүлж тавина.</li> <li>Багш нэг дугуй дүрс зурсан карт харуулаад харгалзах цифрийг /1,2,3/ олуулна. Хүүхэд зөв олж чадвал багш тухайн тоог хэлж өгч, дүрсийг тоолуулна.</li> <li>Багш тоо асууж олуулна. Даалгавар хүнд байвал тооны картыг харуулж дэмжлэг үзүүлнэ.</li> </ol>		

49



*Багш ширээн дээр тоотой карт тавина. Түүнтэй ижил картыг олохыг хүүхдээс хүсэх*



*Багш “..... аль нь вэ?” гэж асуун, тэрхүү тоотой картыг олохыг хүсэх*

### Жишээ

- Картаар тоглоом тоглоно. 1-9 хүртэлх картыг дарааллын дагуу эгнүүлж тавина. Цифрийг оролцогчдын тооноос хамааран тохируулна. Аль болох нэг хүүхэд олон дахин сугалах боломжтойгоор зохион байгуулах.
- 1. Дарааллаар картаа сугалж, гарсан цифрийг эгнүүлсэн картны цифртэй нийлүүлж, тэрхүү нийлүүлсэн картаа өөрийн болгон авна.
- 2. Багш болон ахлагч хүүхдээр картыг бэлдүүлэх. Мөн хэдийн тоо гэдгийг хэлүүлэх.
- 3. Багш хамгийн сүүлд хүүхдүүдээр өөрсдийнх нь сугалж нийлүүлсэн картыг тоолуулж, хамгийн их карттай нь хожсон болохыг хэлж өгнө.
- Сугалсан карттай нь тэнцүү тоотой тоглоомон бөмбөлөг/соронзон тэмдэг/ өгч тоолуулж болно. Энэ тохиолдолд хамгийн сүүлд тухайн зүйлийн их багыг харьцуулуулж тоглоомын ялагчийг хэлж өгнө.

Даалгавар 50	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-3	Үсэг унших	Түвшин 5
Агуулга	4 хүртэл үсэгтэй үгийг харж ойлгон, тохирох зүйлийг олох			
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Хэрэглэгдэхүүн	4-өөс бага үсэгнээс бүрдсэн ойр зуурын эд юмсын нэр, бодит зүйл			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Ширээн дээр хэдэн хэдэн эд юмс тавина.</li> <li>2. Үгт картыг хүүхдээр уншуулж, картан дээр бичсэн зүйлийг сонгуулна. Хүүхэд уншиж чадахгүй байвал үгний эхний хэсгийг уншиж өгнө.</li> <li>3. Тэгээд ч хэцүү байвал бүтэн үгийг уншиж өгнө. Бусад үгт картыг мөн адил аргаар ашиглана.</li> </ol>			



*Багш ширээн дээр бодит зүйл тавина.  
/алим, сүү/ Тэдгээрийг бичсэн карт үзүүлэн  
адил картыг олуулах*



*Олж чадвал үгийн дуудлагыг  
давтан хэлнэ*



### **Анхаарах зүйл**

- Хүүхэд нэрийг нь хэлж чадах, бодитоор зааж асууж чадах зүйл сонгоно.
- Энгийн үед гэр бүлтэй нь хамтран тухайн зүйлийг үгээр хэлүүлж сургах. Хүүхэд таних, нэрийг нь хэлж чадах зүйлийг сонгоно. Хэлж чадахгүй бол гэр бүлтэй нь хамтран тухайн зүйлийг хэлүүлж сургана.

### **Жишээ**

1. Эхлээд бодит зүйлээс эхлэх бөгөөд аажмаар фото зураг болон зурагт карт зэргийг ашиглана.
2. Ширээн дээр үгт карт доош нь харуулж тавиад нэг нэгээр нь хүүхдээр сөхүүлэх. Хүүхдээр тухайн сөхсөн картны үгийг уншуулах.
3. Үгт картыг нийлүүлэх. Чадсан тохиолдолд өөрийн болгох.

Картыг өөр хүн сөхөж байгаа тохиолдолд ч хамт тухайн картны үгийг уншуулах. Хэд хэдэн зурагт карт бэлдэж ганцхан зурагт карт бус олон карт авч чаддаг болгох. Тухайн үгний утгыг ойлгуулах үүднээс үг бэлдэх.

### III-4 Тоо, хэмжээ

Даалгавар 51	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 3
Агуулга	3 хүртэлх тооны ижил зүйлсийг нийлүүлэх			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	1,2,3 дугуй дүрсний зурагт карт тус бүр хэд хэдэн ширхэг			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Тус бүрээс нэг нэгийг ширээн дээр тавина. Багш тусад нь 1 дугуй дүрсний зурагт карт хүүхдэд үзүүлж, багшийн барьсан карттай ижил картыг хүүхдээр олуулна. Хэрвээ хүүхдийн хариулт буруу байвал хүүхдийн сонгосон карт, багшийн карт 2-ыг зэрэгцүүлж тавиад дугуй дүрсний тоо ялгаатай байгааг заавал ойлгуулах.</li> <li>Картаа сольж тухайн карт дээрх тоог хэлүүлж адилхан тоотой картыг олуулна. <ul style="list-style-type: none"> <li>Хэрвээ буруу сонговол, сонгосон карт болон багшийн барьсан картыг зэрэгцүүлэн дугуйны тоо ялгаатай байгааг ойлгуулна.</li> </ul> </li> </ol>			

51



*Хүүхдийн өмнө 3 хүртэлх дугуй дүрс бүхий картууд тавина. Багш 3 дугуй дүрс зурсан карт үзүүлэн ижил картыг олуулах*



*Зөв карт олсон бол ижил картыг зэрэгцүүлэн барьж "Ижилхэн байна, тийм үү?" гэж хамтдаа шалгана.*

#### Жишээ

Дээрх картан дээрх дугуй дүрсийг байнга харж, хэрэглэдэг зүйлийн зургаар сольж, дээрхтэй ижил байдлаар даалгаврыг хийлгэнэ. Үүнийг хийж чаддаг болсны дараа ялгаатай зурагтай, ижил тоотой картуудыг ашиглаж эхэлнэ.

Даалгавар 52	Хэл яриа, танин III мэдэхүй, тоо тоолол	III-4 Тоо тоолол	Түвшин 3
Агуулга	1 гэсэн тооны утгыг ойлгох		
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Бэлдэх зүйл	1,2,3 дугуй дүрс бүхий зурган карт		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Карт тус бүрээс нэг нэгийг ширээн дээр зэрэгцүүлэн тавина.</li> <li>2. “Нэг дүрстэй зурагт картыг авч өгөөрэй” гэж хэлнэ. Хүүхэд 1 дугуй дүрс бүхий зурагт карт сонгож чадвал багшид байгаа карттай адил байгааг хамтдаа шалгаад магтана. <ul style="list-style-type: none"> <li>• Хэрвээ буруу сонговол багшийн карт, хүүхдийн сонгосон картыг зэрэгцүүлж тавиад дугуй дүрсний тоо ялгаатай байгааг ойлгуулна.</li> </ul> </li> </ol>		



Хүүхдээр 1 цагирагтай картыг сонгуулах



Багш 1 цагирагтай ижил картыг үзүүлж ижил байгааг баталгаажуулах

Даалгавар 53	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 3
Агуулга	1 гэсэн тооны утгыг ойлгож, 1 дөрвөлжин шоо тавьсан таваг сонгох			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	1,2,3 ширхэг шоо тавьсан таваг, 1 дугуй дүрс бүхий зурагт карт			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Карт тус бүрээс нэг нэгийг ширээн дээр тавина. /Хүүхдийн өмнө 1,2,3 ширхэг шоо тавьсан тавагнуудыг зэрэгцүүлэн байрлуулна/</li> <li>Багш “Надад нэгийг авч өгөөрэй” гэж хэлнэ. Хүүхэд /1/-ийг сонгож чадвал 1 дугуй дүрс зурсан картан дээрх тоотой адил байгааг шалгаад магтана. <ol style="list-style-type: none"> <li>Хэрвээ буруу сонговол багшийн карт, хүүхдийн сонгосон тавган дээрх шоотой харьцуулан харуулж, тоо нь өөр байгааг ойлгуулна.</li> </ol> </li> </ol>			



Ширээн дээр тус бүр 1,2,3 ширхэг шоотой таваг тавина. Багш дугуй дүрс зурсан картыг үзүүлэн картан дээр байгаа дугуй дүрсийн тоотой ижил тавагтай шоог олуулах



Зөв сонгож чадвал картан дээрх дүрс болон шооны тоог харьцуулж хэлүүлэн адил тоотой байгааг баталгаажуулах

Даалгавар 54	Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 4
Агуулга	3 зүйл хүсэхэд авч өгөх			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	Өнгө, хэлбэр, хэмжээгээрээ адилхан өрдөг модон шоо 5ш, 3 дугуй дүрс зурсан карт			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>5 ширхэг модон шоог ширээн дээр энд тэнд тавина.</li> <li>Багш “Надад 3-ыг аваад өгөөрэй” гэж хэлнэ.</li> <li>Хүүхэд 3 ширхгийг багшид авч өгч чадвал 3 дугуй дүрс зурсан карттай тоо нь адилхан байгааг бататгаад магтана. <ol style="list-style-type: none"> <li>Хэрвээ хүүхэд буруу хийвэл багшийн карт, хүүхдийн авч өгсөн шоог зэрэгцүүлж харуулаад шоо болон картан дээрх дугуй дүрсний тоо өөр байгааг ойлгуулах.</li> <li>Давтан хийсэн ч хүүхэд буруу хийвэл 5 ширхэг өрдөг модон шоог нэг эгнээ болгон ширээн дээр тавиад хүүхдэд тоолоход хялбар болгож өгнө.</li> </ol> </li> </ol>			



*Багш ширээн дээр 5 ширхэг шоо тавиад "Надад 3 ширхэг шоо аваад өгөөрэй" гэж хэлнэ.*



*Хүүхэд хэлсэн тооны шоог багшид авч өгнө. "3 дугуй дүрстэй карт болон шооны тоо ижил байна" гэдгийг баталгаажуулж, сайн гүйцэтгэсэн бол магтана.*

### Жишээ

Хүүхэд бүрт дүрс эсвэл шоог гурав гурваар тараах боломжтой нөхцөл бүрдүүлэх. Олон зүйлээс 3-ыг авч тараах.



Даалгавар 55	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 4
Агуулга	5 ширхэг зүйлийг зааж, тод зөв тоолох			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	Хэмжээ, өнгө, хэлбэр ижил 5 ширхэг өрдөг модон шоо, 5 ширхэг бусад төрлийн зүйлүүд /өнгө, хэлбэр нь ялгаатай модон шоо, товч г.м/			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Ширээн дээр 5 ижил модон шоог эгнүүлж тавина. Хүүхэд хуруугаа хүргэн чангаар тоолно. Хүүхэд зөв тоолж чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>Даалгавар 49-ийг хийж чадсан хүүхдэд 5-ын тоог харуулж болно.</li> <li>Хэрвээ буруу тоолбол багш эхлээд тоолж үзүүлээд хүүхдээр дуурайлган тоолуулна.</li> </ul> </li> <li>/1/-ийг хийж чадвал 5 өөр төрлийн зүйлийг ширээн дээр энд тэнд тарааж тавиад чанга дуугаар тоолуулна. Хүүхдээр нэг эгнээ болгон өрүүлсэн ч болно.</li> </ol>			




*Багш ширээн дээр 5 ширхэг шоо тавина. Хүүхэд шоог хуруугаар зааж, чангаар тоолох*



*Багш ширээн дээр 5 өөр төрлийн зүйлийг тавина. Хүүхэд хуруугаар зааж, чангаар тоолох*

Даалгавар 56	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 5
Агуулга	10 ширхэг зүйл хүсэхэд авч өгөх			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	Хэмжээ, өнгө, хэлбэр нь адилхан 13 ширхэг өрдөг модон шоо, 10 ширхэг дугуй дүрс зурсан карт			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>13 ширхэг өрдөг модон шоог ширээн дээр энд тэнд тарааж тавина.</li> <li>Багш “Надад 10-ыг аваад өгөөрэй” гэж хэлнэ.</li> <li>Хүүхэд 10 модон шоо тоолж өгч чадвал 10 дугуй дүрс зурсан карттай харьцуулж ижил тоотой байгааг бататгаад магтана. <ul style="list-style-type: none"> <li>• Даалгавар 49-ийг хийж чадсан хүүхдэд 10-ын тоог харуулж болно.</li> <li>• Хэрвээ хүүхэд буруу тоолбол 13 ширхэг өрдөг модон шоог нэг эгнээ болгон өрж хүүхэд тоолоход хялбар болгоно.</li> </ul> </li> </ol>			



Багш ширээн дээр 13 ширхэг шоог замбараагүй тавина. Тавган дээр 10 ширхэг шоо тавиарай гэж хүүхдэд хэлнэ.



Хүүхэд багшийн хэлсэн дагуу шоог тавган дээр тавина. Зөв тавьж чадвал 10 дугуй дүрс бүхий карт үзүүлэн ижил байгааг баталгаажуулна.



### Анхаарах зүйл

- Өдөр тутмын амьдралдаа 10 хүртэл тоо тоолж чаддаг болгох.
- Нэг эгнээ болгон өрсөн зүйлийг хуруугаараа хүрч тоолдог болгох.
- Хуруугаараа хүрч тоолсны дараа “Бүгд ... ширхэг” гэж хэлж чаддаг болгох.

### Жишээ

Математикийн хичээл /тоо тоолох даалгавар гүйцэтгэх үед/  
10 хүртэлх мөсний хэв/сав/ ашиглан дотор нь өрдөг модон шоог нэг нэгээр нь хийлгэнэ. Нэгээр нэгээр нь тоолуулж 10 байна гэдгийг бататгах.

Даалгавар 57	III Хэл яриа, ганин мэдэхүй, тоо тоолол	III-4	3-4. Тоо тоолол	Түвшин 5
Агуулга	10 ширхэг хүртэлх зүйлийг зөв, тод тоолох			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	Хэмжээ, өнгө, хэлбэр нь ижил өрдөг модон шоо 10 ш, 5 өөр төрлийн зүйл /өнгө, хэлбэр нь өөр модон шоо, товч г.м/			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>10 ширхэг ижил өрдөг модон шоог эгнүүлж тавиад хуруугаараа шоонд хүрч тоолно. Хүүхэд зөв тоолж чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>• Хэрвээ буруу тоолбол багш яаж тоолохыг тоолж үзүүлээд дуурайн тоолуулна.</li> </ul> </li> <li>Дээрх даалгавар 1-ийг гүйцэтгэж чадвал 10 ширхэг өөр зүйлийг ширээн дээр энд тэнд тавиад чанга дуугаар тоолуулна. Нэг эгнээнд хүүхдээр өрүүлсэн ч болно.</li> </ol>			



*Багш 10 ширхэг шоо өрнө. Хүүхэд нэг бүрчлэн хуруугаар заан тоолох*



*Багш 10 өөр төрлийн зүйлийг тавина. Хүүхэд нэг нэгээр нь хуруугаараа заан тоолно.*




### Анхаарах зүйл



- Өдөр тутмын амьдрал дээр 10 хүртэл тоог тоолж чаддаг болгох.
- Хөгжлийн бэрхшээл, хүүхдийн чадвараас хамааран дээрх даалгаврын агуулгыг ганцаарчлан хийлгэснээр ангид адилхан нэг хичээл оронгоо явуулах боломжтой. Үе шат бүрд нь тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах хэрэгтэй.

Даалгавар 58	Ш Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	Ш-4	3-4. Тоо тоолол	Түвшин 5
Агуулга	5 –ын тоо болон тийм тооны эд зүйлийг харгалзуулах			
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл			
Бэлдэх зүйл	1-5 хүртэлх тооны карт, 1-5 хүртэлх тоогоор дугуй дүрс зурсан карт. Хэмжээ, өнгө, хэлбэр нь ижил 5 ширхэг өрдөг модон шоо			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>5 ширхэг ижил модон шоог эгнүүлээд ширээн дээр тавина. 1-ийн тооны картыг хүүхдэд үзүүлж, “Ийм тооны модон шоог авч өгөөрэй” гэж хэлнэ. Хүүхэд зөв хийж чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>Хэрвээ буруу хийвэл багш карт дээрх тоотой ижил дугуй дүрс зурсан картыг зэрэгцүүлж харуулаад “Ижил тооны юм авч өгөөрэй” гэж дахин хэлнэ.</li> </ul> </li> <li>Даалгавар 1-ийг хийж чадвал өөр тооны картыг мөн адилаар дахин давтана.</li> <li>Даалгавар 2-ыг хийж чадвал эд зүйлийг энд тэнд тавих, өөр төрлийн эд зүйл ашиглаж, ялгаатай 5 төрлийн зүйл /өнгө, хэлбэрээр ялгаатай модон шоо, товч г.м/-ийг ашиглаж, дээрх даалгавруудыг хийлгэнэ.</li> </ol>			



Багш 5 ширхэг шоо эгнүүлж тавин, 1-5 дугуй дүрс зурсан картыг үзүүлэх



Хүүхэд картан дээр зурсан дугуй дүрстэй адил тооны шоог авч өгөх

**! Анхаарах зүйл**

- Тус даалгаврыг математикийн хичээлийн тоо, тооллын агуулгатай уялдуулах.
- Хөгжлийн бэрхшээлийн түвшин, хүүхдийн чадвараас хамааран дээрх даалгаврын агуулгыг ганцаарчлан хийлгэх ангид адилхан нэг хичээл оронгоо явуулах боломжтой.
- Үе шаг бүрд тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах.

### III-5 Эд зүйлийн шинж чанар

Даалгавар 59	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-5 Эд зүйлийн шинж, чанарыг заах	Түвшин 4
Агуулга	2 ижил зүйлийн том, жижгийг ялгах		
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Бэлдэх зүйл	Ижил төрлийн том, жижиг зүйл /том, жижиг өрдөг модон шоо, товч, халбага г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Ижил төрлийн том жижиг зүйл эгнүүлж тавиад “Томыг нь аваад өгөөрэй” гэж хэлнэ. Хүүхэд зөв сонгож чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>Хэрвээ буруу хийвэл багш өөр нэг ижил төрлийн том жижиг зүйл үзүүлээд “Энэ нь том” гэж томыг нь заасныхаа дараа дахиад нэг удаа “Томыг нь аваад өгөөрэй” гэж хэлнэ.</li> </ul> </li> <li>Даалгавар 1-ийг гүйцэтгэж чадвал өөр зүйлийг яг адилхан маягаар асууж хийлгэнэ.</li> <li>Даалгавар 2-ыг гүйцэтгэж чадвал “Жижгийг нь аваад өгөөрэй” гэж хэлээд жижгийг нь сонгуулна.</li> </ol>		

59



*Ширээн дээр жижиг, том дугуй дүрс байршуулан “Том нь аль нь вэ?” гэж асуух*

#### Жишээ

- Том, жижиг зүйлээ урьдчилан бэлтгэх. Багшид том аяга, халбага, хүүхдэд жижиг аяга, халбага бэлдээд багшид томыг нь ангийнхаа найз нарт жижгийг нь тараах даалгавар өгнө.
- Хичээлд тоо тооллын агуулгыг оруулж тухайн үе шатанд тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн хийх.

Хэмжээгээрээ том, дунд, жижиг гэсэн ялгаатай дугуй дүрс зурсан карт бэлтгэх. 3 картнаас том ба дунд зэргийг харьцуулж, дараа нь дунд ба жижгийг харьцуулах даалгаварт шилжих. Дунд зэргийн хэмжээтэй картыг том карттай харьцуулахад жижиг, жижигтэй харьцуулахад том болохыг ойлгуулж, “Том, жижиг” гэсэн ухагдахууныг ойлгуулах.

Даалгавар 60	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-5 Эд зүйлийн шинж, чанарыг заах	Түвшин 5
Агуулга	2 харандааны уртыг сонгох		
Ямар үед	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Бэлдэх зүйл	Урт, богино харандаа хэд хэдэн төрлийг бэлдэх		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Урт, богино харандааны “Уртыг нь аваад өгөөрэй” гэж хэлнэ. Хүүхэд зөв сонгож чадвал магтана. <ul style="list-style-type: none"> <li>Хэрвээ буруу хийвэл багш өөр урт, богино мод харуулаад “Энэ нь урт” гэж хэлээд урт модыг заагаад хүүхдэд дахин нэг удаа “Уртыг нь аваад өгөөрэй” гэж хэлнэ.</li> </ul> </li> <li>Дээрх даалгаврыг хийж чадвал өөр зүйл дээр адилхан маягаар асууна.</li> </ol>		



*Багш урт, богино 2 шугам зэрэгцүүлж тавин “Аль нь урт вэ?” гэж хүүхдээс асуух*

### Жишээ

Том, жижгийн жишээтэй адилхан өгөгдөлтэй даалгавар ажиллана.

### III-6 Эд юмсын зориулалт

Даалгавар 61	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-6 Эд юмсын зориулалт	Түвшин 4
Агуулга	Эд юмсыг зориулалтаар нь ангилах, нэрлэх		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Төрөл бүрийн зурагт карт /малгай, гутал, хайч, харандаа, толгой /нүүр, хөл, цаас/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. “Малгай”, “Гутал”-ны зурагт картыг зэрэгцүүлж тавиад “Толгой/нүүр”-ны зурагт картыг үзүүлээд “Толгойдоо өмсдөг нь аль вэ?” гэж асууна. <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд хэцүү байвал малгай өмсөж буй дүр үзүүлнэ.</li> </ul> </li> <li>2. Хүүхэд малгайны зурагт картыг сонгож чадвал малгай өмсөж буй дүр үзүүлээд “Тийм байна, зөв байна. Малгай өмсөнө” гэж хэлнэ. Хүүхэд сонгож чадахгүй байсан ч адилхан үйлдлийг хийж үзүүлэнгээ “малгай өмсөнө” гэж хэлээд малгайны зурагт картыг харуулна.</li> <li>3. Дараа нь “хөл”-ний зурагт картыг үзүүлээд “хөлдөө өмсдөг нь аль вэ?” гэж асууна. Даалгавар 1-тэй адилхан “гутал”-ын зурагт картыг сонгуулна.</li> <li>4. “малгай” болон “гутал”-ны зурагт картыг зэрэгцүүлж тавиад зурагт картгүйгээр “толгойдоо өмсдөг юм”, “хөлдөө өмсдөг юм” гэж асуун зөв хариултыг хүүхдээр сонгуулна. <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдэд хэцүү байвал толгой, хөлний зурагт карт болон үйл хөдлөлөөр үзүүлж дэмжих.</li> </ul> </li> <li>5. Дээрх даалгавруудын адил “хайч”, “харандаа”-ны зурагт картыг зэрэгцүүлж тавиад “цаас”-ны зурагт картыг үзүүлээд “хайчилдаг нь аль вэ?”, “бичдэг нь аль вэ?” гэж асууна.</li> </ol>		

61



Багш “Малгай” ба “Гутал”-ны зурагт карт зэрэгцүүлж тавих



Хүүхдэд “Толгой”-ны зурагт карт үзүүлэн “Толгойдоо өмсдөг нь аль нь вэ” гэж асууна. Зөв сонгож чадаж байвал “Зөв, толгойд малгайг өмсдөг шүү дээ” гэж өмсөж үзүүлэх

Даалгавар 62	III Хэл яриа, танин мэдэхүй, тоо тоолол	III-6 Эд юмсын зориулалт	Түвшин 5
Агуулга	Эд юмсын зориулалтаар нь тайлбарлах		
Орчин	Математик, Монгол хэл, ганцаарчилсан хичээл		
Хэрэглэгдэхүүн	Зурагт карт “малгай, гутал, хайч, харандаа, толгой/нүүр, хөл, цаас”		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>“малгай”-ны зурагт карт тавиад “Малгайг яадаг билээ?” гэж асууна. <ul style="list-style-type: none"> <li>Хүүхдэд хэцүү байвал толгой/нүүр-ны зурагт картыг үзүүлэх, өмсөж үзүүлэх. “Өмсөх” эсвэл “Малгай өмсөх” гэж бүтэн өгүүлдбэрээр хэлүүлэх.</li> </ul> </li> <li>Мөн адил “гутал” - “өмсөх”, “хайч” - “хайчлах”, “харандаа” - “бичих” гэх мэтээр картаа үзүүлэн үйлдлийг хэлүүлнэ.</li> </ol>		



Багш малгайны зурагт карт тавин, “Малгайг яадаг билээ?” гэж асуух



Хүүхэд “Өмсөнө” гэж хариулах

### ! Анхаарах зүйл

- Өдөр тутмын амьдрал дээр хувцас солих, гэр цэвэрлэх зэрэг үйлдлүүдийг хийлгэж, тухайн эд юмсын нэр болон үйл хөдлөлийг үгээр сайтар хэлж дасгаж байх.

### Жишээ

- Монгол хэл, нийгэм ахуйн баримжаа зэрэг хичээлийн агуулгад оруулах.
- Хүүхдүүдийн дуртай, дассан дуу хөгжим ашиглаж, “Малгай урагдах, гутал өмсөх” зэргээр дуунд оруулж, хөгжмийн хэмнэлд нийцүүлэн биеийн хөдөлгөөнөөр үзүүлэн, хөгжилтэй байдлаар ойлгуулах.



## IV ХАРИЛЦАА, НИЙГЭМШИХҮЙ

### IV-1 Өөрийгөө илэрхийлэх

Даалгавар 63	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-1 Өөрийгөө илэрхийлэх	Түвшин 2
Агуулга	2 зүйлийн 1-ийг нь зааж, гараар хүрч сонгох		
Орчин	Даалгавар хийх болон тоглох үед багш хэрэглэгдэхүүнийг сонгож өгөх бус, болж өгвөл хүүхдээр өөрөөр нь 2 зүйлийн аль нэгийг сонгуулах.		
Хэрэглэгдэхүүн	Даалгавар болон тоглоом хэрэгсэл /өнгийн харандаа, пазл, өрдөг модон шоо г.м/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Багш 2 гартаа өөр өөр зүйл барьж үзүүлээд алийг нь хиймээр байгаа санал асуух.</li> <li>2. Хүүхэд нэгийг нь сонгон гарт хуруугаараа хүрч заах юм уу зааж чадвал сонгож байгааг магтаж, тухайн үйлийг хүүхдэд тайлбарлаж өгч даалгаврыг хийлгэх, тоглуулах.</li> </ol>		

63



*Багш 2 зүйл зэрэгцүүлэн тавьж аль нэгийг нь сонгуулах*



*Хүүхэд аль нэгд нь хүрч сонгоход магтан, түүгээр тоглуулах*



#### Анхаарах зүйл

Хүүхдийн дуртай зүйлийг өдөр тутмын үйл ажиллагаанаас олж нээн, хүүхдийн сонголтыг олшруулах.

Даалгавар 64	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-1 Өөрийгөө илэрхийлэх	Түвшин 3
Агуулга	2 зурагнаас таалагдсанаа сонгох		
Орчин	Даалгавар хийх болон тоглох үед багш өөрөө бэлдэж өгөх бус, болж өгвөл хүүхдээр 2 зүйлийн аль нэгийг сонгуулах.		
Хэрэглэгдэхүүн	Даалгавар болон тоглоомын агуулгыг илэрхийлэх хялбар зураг		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Даалгавар болон тоглоомын агуулгыг илэрхийлсэн 2-3 ширхэг зургийг ширээн дээр тавиад алийг нь хиймээр байгаа саналыг асуух.</li> <li>2. Хүүхэд гараараа сонгож чадвал сонгосон зургийг хүүхдэд өгөөд даалгавар, тоглоомыг нь хийлгэх /үгээр хэлэхгүй байж болно/</li> </ol>		



*Багш зураг будаж байгаа, дуу дуулж байгаа үйл хөдлөлтэй зурагт карт тавих*



*Хүүхэд түүнээс дуртайгаа сонгох*



### **Анхаарах зүйл**



Даалгавар болон тоглоомын агуулгыг илэрхийлсэн картыг өдөр тутамд хийх зүйлийн төлөвлөгөө, хуваарь, юуг яаж хийх тухай тайлбарлах үед ашиглаж, хүүхдийн нүдэнд дасгах.

Даалгавар 65	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-1 Өөрийгөө илэрхийлэх	Түвшин 3
Агуулга	"Надаа" гэдэг үгийг үйлдлээр үзүүлэх эсвэл үгээр илэрхийлэх		
Орчин	Хүүхэд өөрийгөө дохио зангаагаар болон үгээр илэрхийлж чаддаг болох		
Хэрэглэгдэхүүн	Идэх дуртай, тоглох дуртай зүйл		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхэд ямар нэг зүйлийг хүсэхэд багш шууд өгөх биш, "Надаа" гэж дохиогоор, үйлдлээр хийлгүүлэх. /Ярьж чадахгүй хүүхдийн хувьд үгээр илэрхийлэхийг шаардахгүй/  <ul style="list-style-type: none"> <li>• Хэрвээ хүүхэд хийж чадахгүй байвал багш хүүхдийн 2 гараас барьж "Надаа" гэж алгаа тосч үзүүлэх. Багш өөрөө үзүүлэх.</li> </ul> </li> <li>2. Ярьж чаддаг бол дохиогоор үзүүлэх болон "Надаа" гэж хэлүүлж болно. Чанга дуугаар "Надаа" гэж хэлүүлэх тохиолдолд багш үгийн эхний "На" үеийг хэлж, үлдсэнийг нь хүүхдээр хэлүүлэх гэх мэт.</li> <li>3. Хүүхэд хүслээ илэрхийлж чадсан тохиолдолд хүүхдийн хүссэн зүйлийг өгч, бусдад ойлгогдсоныг ойлгуулах, мэдрүүлэх.</li> </ol>		

65



*Хүүхэд хүсэж буй зүйлээ авах үед "Надаа" гэдэг дохио өгөх*



*Хүүхэд зөв хэлж, тодорхой үйлдэл гаргасан тохиолдолд хүссэн зүйлийг нь өгөх*



### **Анхаарах зүйл**

- Эхлээд "Надаа" гэдэг үйлдлийг дуурайлган хийлгэх. Энэ нь бусад үйлдлийг илэрхийлэх дохио /бие засах, юм уух г.м/-г сурахад дөхөм болно. Бусад орчинд янз бүрийн нөхцөл байдалд дохио ашиглуулах.

Даалгавар 66	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-1 Өөрийгөө илэрхийлэх	Түвшин 4
Агуулга	Өөрийгөө илэрхийлэхдээ зурагт карт ашиглах		
Орчин	Ариун цэврийн өрөө явах, хоол идэх, нэг даалгавар хийхээс өмнө		
Хэрэглэгдэхүүн	Даалгавар ба тоглоомны агуулгыг илэрхийлсэн том хэмжээтэй хэд хэдэн зурагт карт /сонгуулах/		
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхдийн урд зурагт картыг байрлуулах.</li> <li>2. Хүүхэд багшид хандан тухайн картыг хуруугаараа зааж хүслээ илэрхийлж чадвал тухайн даалгавар /тоглоом/-ыг хийлгүүлэх. Зурагт карт нь зөвхөн даалгавар, тоглоом бус “бие засах” гэх мэт байж болно. /Хүүхэд өөрийгөө илэрхийлэх нь чухал тул хүслийг нь биелүүлж өгөх/</li> </ol>		



*Багш “Юм уух”, “Ариун цэврийн өрөө явах” гэх мэт зурагт картыг эгнүүлж тавих*



*Хүүхдээс саналыг асуун сонгуулна. Өөрийн хэрэгцээг илэрхийлж чадаж байвал тэрхүү үйл хөдлөлийг нь хийлгэх /юм ууж байгаа карт сонгосон тул уух юм өгнө/*


### ! Анхаарах зүйл

- Даалгавар болон тоглоомны картыг өдөр тутамд сургууль дээр, гэртээ юу хийх тухай тайлбарлахдаа ашиглах. Мөн “бие засах”, “юм уух” зэрэг хэрэгцээ гарахад энэхүү картыг ашиглаж илэрхийлж сурах. Зурагт карт болон үйлдлийн холбоо хамаарлыг ойлгуулах.

## IV-2 Өдөр тутмын амьдрал дээрх нийтлэг дүрэм

Даалгавар 67	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-2	Өдөр тутмын амьдралын нийтлэг дүрэм	Түвшин 4
Агуулга	Ээлж дарааллыг ойлгуулах тоглоом тоглох			
Орчин	Тоглоомын цагаар болон ганцаарчилсан хичээл			
Хэрэглэгдэхүүн	Өрдөг модон шоо /2 төрлийн өнгөтэй, 7-9 ширхэг/			
Дараалал	<ol style="list-style-type: none"> <li>Ширээн дээр хэд хэдэн модон шоо тавина. Багш модон шооноос нэгийг авч, хүүхдийн өмнө тавиад “Энэ шоон дээр дахиад нэг модон шоо тавиарай” гэж хэлнэ. <ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд хариу үйлдэл хийхгүй бол хүүхдийн гарт бариулаад өрүүлж үзүүлнэ. Хүүхэд 2-оос дээш модон шоо өрөхөөр оролдож байвал зөвхөн нэгийг л өрнө гэж анхааруулна.</li> </ul> </li> <li>Багш “За одоо, багшийн ээлж” гэж хэлэн нэг модон шоо дээр нь тавина.</li> <li>“Одоо /хүүхдийн нэрийг хэлнэ/-ний ээлж” гэж хэлээд хүүхдээр өрүүлнэ. Хүүхдийн ээлж ирсэн үед нэрийг хэлэх эсвэл гараараа дохино. Багшийн ээлж ирсэн үед “Одоо багш нь” гэж хэлэн, өөрлүүгээ заах зэргээр дарааллыг зааж өгнө. Энэ мэтчилэн аажмаар зааварчилгааг багасгаж, хүүхэд өөрийн ээлж дарааллыг ойлгодог болох хүртэл өрүүлж чиглүүлнэ.</li> </ol>			

67



Хүүхэд, багш хоёр ээлжлэн шоог өрөх

Даалгавар 68	IV Харилцаа, нийгэмшихүй	IV-2 Өдөр тутмын амьдралын нийтлэг дүрэм	Түвшин 5
Агуулга	"За, май ", "Баярлалаа", "Уучлаарай" зэрэг үгийг хэрэглэж хэвших		
Орчин	Бусдад суудал/дараалал тавьж өгөх, эд юмс өгөх, бусдаас туслалцаа авах, бусдад төвөг удсан нөхцөл байдалд		
Хэрэглэгдэхүүн	байхгүй		
Дараалал	1. Бусдад суудал/дараалал тавьж өгөх, эд юмс өгөх, туслалцаа авах, төвөг удсан үед “За, май ”, “Баярлалаа”, “Уучлаарай” гэсэн үгийг хэрэглэж хэвшүүлнэ. Багш эхлээд дуурайлган хийлгүүлнэ. Үгийн эхний үеийн дуулагыг хэлж өгч үргэлжлэлийг нь хүүхдээр хэлүүлнэ. Хүүхэд зөв үгээр илэрхийлж хэрэглэсэн тохиолдолд магтана.		



### Анхаарах зүйл

- Өдөр тутмын амьдралдаа хэрэглэж чаддаг болгохын тулд гэр бүлтэй нь хамтран ажиллах нь зүйтэй. Хүүхэд нөхцөл байдалд тохирсон үгийг хэлсэн тохиолдолд ангийн хүүхдүүдийн дэргэд багшийн зүгээс магтана.

### Жишээ

“За, май”, “Баярлалаа”, “Уучлаарай” зэрэг үгийг ашиглах жишээгээр видео хийж, бодитоор үзүүлж төсөөлөл суулгах, дуурайж хийлгэн хэвшүүлэх шаардлагатай.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ,  
БАГШЛАХ АРГА ЗҮЙН ГАРЫН АВЛАГА

---

